

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

535.	Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2125
536.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2128
537.	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/	2131
538.	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	2158
539.	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай	2159
540.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2161
541.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2162
542.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2163
543.	Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2164
544.	Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2165
545.	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2166
546.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2167
547.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2168
548.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2170

549.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай		2171
550.	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		2172
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ			
551.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 41	2173
552.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 45	2174
553.	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 46	2175
554.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай	Дугаар 50	2177
555.	Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 51	2178
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
556.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 39	2179
557.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 40	2179
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
558.	Журам шинэчлэн батлах, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 8	2180
559.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 19	2210
560.	Журам батлах тухай	Дугаар 36	2223



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд доор дурдсан агуулгатай 39¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“39¹ дүгээр зүйл. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах

39¹.1. Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэхдээ тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаар асуулт асуух, санал өгөх эрхээ Улсын Их Хурлын албан ёсны санал авах цахим хуудас, гар утас, хөдөлгөөнт төхөөрөмжид зориулсан Улсын Их Хурлын албан ёсны программ хангамж /цаашид “цахим хуудас” гэх/-аар дамжуулан хэрэгжүүлж болно.

39¹.2. Улсын Их Хурал Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т заасныг үндэслэн шийдвэр гаргахдаа иргэдийн оролцоог хангах зорилгоор энэ хуулийн 39¹.1-д заасан саналыг санал авах цахим хуудсанд 30 хоногийн хугацаатай байршуулах ба иргэдийн санал дараах тоонд хүрсэн тохиолдолд хэлэлцэнэ:

39¹.2.1. тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах саналыг 33 000 ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол;

39¹.2.2. Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах саналыг 70 000 ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9.3-т заасны дагуу;

39¹.2.3. хуулийн төслийн талаарх саналыг 100 000 ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол.

39¹.3. Энэ хуулийн 39¹.1-д заасан асуултыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109.11, 109.12, 109.13, 109.14-т заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/94 дүгээр зүйлийн 94.2-94.6 дахь хэсэг:

“94.2. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39¹ дүгээр зүйлд заасан саналыг доор дурдсан тохиолдолд хэлэлцэнэ:

94.2.1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39¹.2-т заасан саналыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэд дэмжсэн бол.

94.3. Иргэн тухайн асуудлаар саналаа зөвхөн нэг удаа өгнө.

94.4. Энэ хуулийн 94.2-т заасан санал авах ажилд мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүргийг Тамгын газар хэрэгжүүлнэ.

94.5. Байнгын хороо энэ хуулийн 94.2-т заасны дагуу тухайн асуудлыг хэлэлцээд бодлогын баримт бичиг боловсруулах, хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг арилгах асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх, Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах, олон нийтийн хэлэлцүүлэг, нийтийн сонголт зохион байгуулах, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах эсэх асуудлыг шийдвэрлэж, шаардлагатай гэж үзвэл санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна.

94.6. Байнгын хороо энэ хуулийн 94.2-т заасан асуудлыг хэлэлцэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг баримтална.”

2/109 дүгээр зүйлийн 109.11-109.14 дэх хэсэг:

“109.11. Энэ хуулийн 109.2-т заасан мэдээллийг ирүүлмэгц сэдвийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39¹.1-д заасан цахим хуудсанд тав хоногийн хугацаанд иргэдээс асуулт асуухаар байршуулна.

109.12.Энэ хуулийн 109.11-д заасан цахим хуудсанд иргэдээс ирүүлсэн асуултыг Тамгын газар нэгтгэж нам, эвслийн бүлгүүдэд хүргүүлнэ.

109.13.Энэ хуулийн 109.12-т заасан асуултыг нам, эвслийн бүлэг ангилан багцалж, нам, эвслийн бүлэг тус бүрээс нэг гишүүн төлөөлж Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс асуулт асуух, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно.

109.14.Энэ хуулийн 109.13-т заасан хугацаа нь энэ хуулийн 109.7-д заасан хугацаанд хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Зөвшөөрөгчид

᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр

Зөвшөөрөгчид /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /
Зөвшөөрөгчид /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр

᠖ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /
᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /

᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /

᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /
᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /

᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /
᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /

᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /
᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /

᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /
᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /

᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /
᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /

᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /
᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠗ - ᠒᠙ өдөр /

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнийг байгуулах, паркийн зорилго, зарчим, хэлбэрийг тогтоох, паркийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, төрөөс үзүүлэх дэмжлэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын хууль тогтоомж

2.1.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, түүний удирдлага, нэгжийн үйл ажиллагааны зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тогтооходой холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Үйлдвэрлэл, технологийн паркийн хот байгуулалт, дэд бүтэц, барилга байгууламжийг барьж байгуулахтай холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“үйлдвэрлэл, технологийн парк” /цаашид “парк” гэх/
гэж үйлдвэрлэл, технологийн хөгжлийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэх

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

тусгайлсан нутаг дэвсгэр, бизнесийн таатай орчин, дэд бүтцийн хангамж бүхий, тодорхой салбарт үйл ажиллагаагаар харилцан уялдсан үйлдвэрлэл, технологийн цогцолборыг;

4.1.2.“паркийн удирдлага” гэж паркийн үйл ажиллагааг зохион байгуулах, хөгжүүлэх чиг үүрэг бүхий тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг;

4.1.3.“паркийн нэгж” гэж паркийн удирдлагатай байгуулсан гэрээний үндсэн дээр паркийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд, бизнес инкубатор, сургалт, судалгаа хөгжлийн байгууллагыг;

4.1.4.“судалгаа хөгжлийн байгууллага” гэж паркт шинжлэх ухаан, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, туршилт, зохион бүтээх ажил эрхлэх, дэвшилтэт техник, технологийг дамжуулах, нутагшуулах замаар бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх үүрэг бүхий байгууллагыг;

4.1.5.“паркийн дэд бүтэц” гэж паркийн нутаг дэвсгэрт эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам бүхий цогцолборыг;

4.1.6.“паркийн хөгжлийн төлөвлөгөө” гэж нэгжийн техник, эдийн засгийн үндэслэл, техник, технологийн түвшин болон зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, кластерын зарчимд суурилсан хөгжлийн баримт бичгийг.

5 дугаар зүйл. Паркийн зорилго, хэлбэр, зарчим

5.1. Паркийг дараах зорилгоор байгуулна:

5.1.1. улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд онцгой ач холбогдолтой импортыг орлох, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний хэмжээний төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

5.1.2. байгаль орчинд ээлтэй, шинэ, дэвшилтэт болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах;

5.1.3. байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

5.1.4. улсын болон бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих;

5.1.5. жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох;



5.1.6. хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

5.2. Паркийн удирдлага өмчлөлийн хувьд дараах хэлбэртэй байна:

- 5.2.1. төрийн өмчит;
- 5.2.2. орон нутгийн өмчит;
- 5.2.3. хувийн өмчит;
- 5.2.4. бусад.

5.3. Парк үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

- 5.3.1. өрсөлдөөнийг хязгаарлахгүй байх;
- 5.3.2. ашиг сонирхлоос ангид байх;
- 5.3.3. үр ашигтай байх;
- 5.3.4. ил тод, нээлттэй байх;
- 5.3.5. тогтвортой, тасралтгүй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ПАРКИЙН ТАЛААР ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

6.1. Улсын Их Хурал үйлдвэрлэл, технологийн паркийн болон түүнтэй холбогдох бусад хууль тогтоомжийг батлах, тэдгээрийн биелэлтийг хянан шалгана.

7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

7.1. Засгийн газар паркийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. паркийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

7.1.2. паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;

7.1.3. энэ хуулийн 5.2.1-д заасан паркийн удирдлагыг байгуулах, дүрмийг батлах;

7.1.4. паркийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих асуудлаар холбогдох дүрэм, журам, заавар баталж мөрдүүлэх;

7.1.5.Газрын тухай хуулийн² 16.1.16-д заасан зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах;

7.1.6.парк эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалтыг үйлдвэржилт, урт, дунд хугацааны хөгжлийн болон инновацийн бодлого, дэд бүтцийн хөгжил, түүхий эд, ажиллах хүчний нөөц, зах зээлийн эрэлт, хэрэгцээг харгалзан батлах;

7.1.7.парк үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх, худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;

7.1.8.хуульд заасан бусад бүрэн эрх.

8 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд³ заасан үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ паркийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.харьяалах асуудлаар паркийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтийг хангуулах, хяналт тавих;

8.1.2.дэвшилтэт техник, технологийн судалгаа хийх, бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ, эрэлт хэрэгцээний хэтийн төлөвийг тодорхойлох зорилгоор паркийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх, холбогдох журмыг батлах;

8.1.3.паркийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судлах, үнэлэх, дүгнэлт гаргах;

8.1.4.парк шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх, бэлтгэх, давтан сургах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

8.1.5.паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох талаар санал боловсруулж, Засгийн газраар шийдвэрлүүлэх;

8.1.6.паркийн удирдлагатай гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих, дүгнэх;

²Газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

³Монгол Улсын Засгийн газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1993 оны 03 дугаарт нийтлэгдсэн.



8.1.7.паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байгуулах, дүрмийг батлах;

8.1.8.үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, зах зээлийг өргөтгөх, шинэ технологи нэвтрүүлэх, мэргэжлийн үйл ажиллагааны стандарт тогтоох, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, хөрөнгө оруулалт татах, сурталчлах чиглэлээр мэргэжлийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

8.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

9.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал паркийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.энэ хуулийн 7.1.6-д заасан жагсаалтын дагуу паркийн нутаг дэвсгэр, байршлыг тогтоох;

9.1.2.Газрын тухай хуулийн 16.1.16-д заасан зориулалтаар газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, гаргах;

9.1.3.паркийн дэд бүтцийг барьж байгуулах асуудлыг үнэт цаас гаргах, төр, хувийн хэвшлийн оролцоог дэмжих болон бусад хэлбэрээр шийдвэрлэх;

9.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

10 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

10.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга паркийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.паркийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлд хяналт тавих;

10.1.2.холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн паркийн удирдлагад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэн, гэрээ байгуулах;

10.1.3.энэ хуулийн 5.2.3, 5.2.4-т заасан паркийн газрыг эзэмшүүлж, ашиглуулах асуудлыг Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэх;

10.1.4.харьяалах нутаг дэвсгэртээ үйлдвэрлэл, технологийн парк байгуулахад дэмжлэг үзүүлэх;

10.1.5.харьяалах нутаг дэвсгэртээ үйлдвэрлэл, технологийн паркийн асуудлаар гарсан шийдвэр, хэрэгжүүлж байгаа төслийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлэх;

10.1.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ПАРКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

11 дүгээр зүйл. Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах

11.1. Дараах шаардлагыг хангасан хуулийн этгээд парк байгуулах тухай хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

11.1.1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулсан байх;

11.1.2. Монгол Улсад татвар төлөгч байх;

11.1.3. паркийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүү, эдийн засаг, техник, технологи, менежментийн чадавхтай нэгжтэй байх;

11.1.4. энэ хуулийн 5.2.1-д заасан паркийн үйл ажиллагаа явуулах этгээд нь төрийн өмчит хуулийн этгээд байх.

11.2. Тусгай зөвшөөрөл хүсэгч Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан баримт бичгээс гадна доор дурдсан баримт бичгийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ:

11.2.1. паркийн нэгжийн техник, эдийн засгийн үндэслэл;

11.2.2. паркийн хөгжлийн төлөвлөгөө;

11.2.3. паркийн нэгжийн техник, технологийн түвшний үнэлгээ;

11.2.4. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

11.2.5. гэрээ байгуулах паркийн нэгжийн жагсаалт;

11.2.6. тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын санал.

11.3. Энэ хуулийн 7.1.2-т заасан тусгай зөвшөөрлийг 15 хүртэл жилийн хугацаатайгаар олгоно.

11.4. Тусгай зөвшөөрлийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага паркийн удирдлагатай тусгай зөвшөөрлийн хугацаагаар гэрээ байгуулна.

11.5.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.4-т заасан гэрээг жил бүр дүгнэж, Засгийн газарт танилцуулна.

11.6.Энэ хуулийн 11.3-т заасан хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтээ, холбогдох баримт бичгийн хамт төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

11.7.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.6-д заасан хүсэлтийг хүлээн авч, гэрээг дүгнэн, үр ашигтай хэрэгжүүлсэн гэж үзсэн бол тусгай зөвшөөрлийг 15 хүртэл жилийн хугацаагаар сунгах саналыг гаргаж, Засгийн газар уг саналыг үндэслэн сунгах эсэхийг шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

12.1.Холбогдох хуульд заасан эрх бүхий байгууллага паркийн үйл ажиллагаанд дараах зөрчил илэрсэн талаар дүгнэлт гаргасан бол тухайн хуулийн этгээдэд олгосон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай саналаа төрийн захиргааны төв байгууллагад гаргана:

12.1.1.паркийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа эрхлээгүй болон төлөвлөгөөнд зааснаас өөр үйл ажиллагаа эрхэлсэн;

12.1.2.төрөөс үзүүлсэн дэмжлэгийг зориулалтын бусаар ашигласан;

12.1.3.гэрээнд заасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйл ажиллагаа эхлээгүй;

12.1.4.хууль болон гэрээнд заасан бусад тохиолдолд.

12.2.Энэ хуулийн 12.1 дэх хэсэг, эсхүл Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасныг үндэслэн энэ хуулийн 7.1.2-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

12.3.Энэ хуулийн 17 дугаар зүйл, эсхүл Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 7.1.2-т заасны дагуу хүчингүй болгоно.

12.4.Энэ хуулийн 12.2-т заасан түдгэлзүүлсэн нөхцөл байдал арилсан бол тусгай зөвшөөрлийн хугацааг энэ хуулийн 7.1.2-т заасны дагуу сэргээнэ.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ПАРКИЙН УДИРДЛАГА, НЭГЖ ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ**

13 дугаар зүйл. Паркийн удирдлага, нэгж түүний эрх, үүрэг

13.1. Паркийн удирдлага нь Компанийн тухай хуулийн⁴ дагуу үүсгэн байгуулагдсан компанийн хэлбэртэй байна.

13.2. Паркийн удирдлагын зохион байгуулалт, засаглал, хяналт, үйл ажиллагаатай холбоотой бусад харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна.

13.3. Паркийн удирдлага дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

13.3.1. төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах;

13.3.2. паркийн нэгжтэй техник, эдийн засгийн үндэслэл, техник, технологийн түвшний болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангуулах;

13.3.3. энэ хуулийн 13.3.2-т заасны дагуу гэрээ байгуулснаар паркийн нэгжид үйлчилгээ үзүүлсний хураамж авах;

13.3.4. паркийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шаардагдах дэд бүтцийг барьж байгуулах, эзэмших, түүний хэвийн үйл ажиллагааг хангах;

13.3.5. паркийн зориулалтаар олгогдсон тусгай хэрэгцээний газрыг зориулалтын дагуу эзэмших, ашиглах, паркийн нэгжид газрыг гэрээний үндсэн дээр ашиглуулах;

13.3.6. энэ хуулийн 8.1.2-т заасан мэдээллийн санд паркийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл өгөх, авах;

13.3.7. энэ хуулийн дагуу үзүүлэх дэмжлэгийг авах;

13.3.8. паркийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн паркийн нэгжид хөрөнгө оруулалт татах, бүтээгдэхүүнээ борлуулах, хүний нөөцийг бүрдүүлэх, санхүүгийн үйлчилгээ авахад зуучлах, бусад шаардлагатай үйлчилгээ үзүүлэх.

13.4. Паркийн нэгж дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

⁴Компанийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.



13.4.1.паркийн удирдлагатай энэ хуулийн 13.3.2, 13.3.5-д заасан гэрээ байгуулж, паркийн удирдлагыг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

13.4.2.энэ хуулийн дагуу үзүүлэх дэмжлэгийг авах;

13.4.3.энэ хуулийн 8.1.2-т заасан мэдээллийн санд паркийн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл өгөх, авах;

13.4.4.энэ хуулийн 13.3.3-т заасан гэрээний дагуу холбогдох хураамжийг төлөх;

13.4.5.паркийн удирдлагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах;

13.4.6.паркийн дэд бүтцийг тэгш эрхтэй ашиглах.

13.5.Энэ хуулийн 13.3.5-д заасан гэрээнд ашиглуулах газрын хэмжээ, байршил, хугацааг тусгасан байна.

13.6.Паркийн нэгжээс паркийн удирдлагад төлөх хураамжийн хэмжээ, төлөх журмыг Засгийн газар тогтооно.

14 дүгээр зүйл. Паркийн удирдлагын үйл ажиллагааны орлого

14.1.Паркийн удирдлагын үйл ажиллагаа нь дараах орлогоос санхүүжинэ:

14.1.1.өөрийн үйл ажиллагааны орлого;

14.1.2.паркийн нэгжид үйлчилгээ үзүүлсний хураамж;

14.1.3.хуулиар зөвшөөрсөн бусад.

ТАВДУГААР БҮЛЭГ ПАРКТ ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

15 дугаар зүйл. Паркт тавигдах шаардлага

15.1.Парк нь дараах шаардлагыг хангасан байна:

15.1.1.бизнесийг дэмжих зорилгоор нээлттэй, ил тод, шударга өрсөлдөөнд суурилсан байх;

15.1.2.хот байгуулалтын норм, дүрэм, стандартыг хангасан байх;

15.1.3.паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах этгээдэд хөрөнгө оруулалт татах, үйл ажиллагаа явуулах таатай, тогтвортой орчныг бүрдүүлсэн байх;

15.1.4.байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй байх;

15.1.5.төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалтыг дэмжих, харилцан хамгаалах;

15.1.6.паркийн нутаг дэвсгэр нь авто болон төмөр зам зэрэг шаардлагатай дэд бүтэцтэй байх буюу эдгээр дэд бүтцийг хөгжүүлэх боломжтой байх;

15.1.7.паркийн нутаг дэвсгэрт хэрэгжих төсөл хөтөлбөр, түүний дэд бүтэц, бүтээн байгуулалтад шаардлагатай усан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан байх;

15.1.8.улс, орон нутгийн тогтвортой хөгжил, эдийн засгийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, мэргэжлийн ажилтныг бэлтгэх нарийвчилсан төлөвлөгөөтэй байх;

15.1.9.хуульд заасан бусад.

15.2.Парк нь сургалт, судалгаа хөгжлийн болон бизнес инкубаторын үйлчилгээ үзүүлдэг нэгжтэй байж болно.

16 дугаар зүйл. Паркийн үйл ажиллагаанд төрөөс үзүүлэх дэмжлэг

16.1. Паркийн үйл ажиллагаанд төрөөс дараах төрлийн дэмжлэгийг үзүүлж болно:

16.1.1. паркийн удирдлага, нэгжийн үйл ажиллагаанд татварын дэмжлэг үзүүлэх;

16.1.2. паркийн үйл ажиллагааг төрөөс дэмжихэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор үнэт цаас гаргах, гадаадын хөнгөлөлттэй зээлд хөрөнгийн баталгаа гаргах;

16.1.3. паркийн дэд бүтэц, барилга байгууламжийг барихад төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, оролцоог дэмжих;

16.1.4. паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын бонд болон холбогдох бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх;



16.1.5.паркийн нутаг дэвсгэрт гаалийн тусгай бүс, гаалийн баталгаат үйлдвэр байгуулах;

16.1.6.төсөл, хөтөлбөртэй холбоотойгоор шаардлагатай зөвшөөрөл авахад дэмжлэг үзүүлэх;

16.1.7.гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсэн горимоор олгох;

16.1.8.паркийн удирдлага, нэгж үйлдвэрлэлийн ажилчдыг сургах, дадлагажуулах зорилгоор гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ үзүүлсэн бол ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх;

16.1.9.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн⁵ дагуу тогтворжуулах гэрчилгээ олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах;

16.1.10.хуульд заасан бусад дэмжлэг.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан дэмжлэг нь зөвхөн паркийн нутаг дэвсгэрт эрхлэх үйл ажиллагаанд хамаарна.

16.3.Энэ хуулийн 16.1-д заасан дэмжлэгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үзүүлнэ.

16.4.Доор дурдсан тохиолдолд паркийн нэгжид төрөөс үзүүлсэн дэмжлэгийг цуцалж, төсөвт бий болсон татварын зарлагыг тухайн нөхцөл байдал тогтоогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор буцаан төлүүлнэ:

16.4.1.паркийн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болохоос өмнө дампуурснаас бусад шалтгаанаар татан буугдсан бол;

16.4.2.паркийн нэгж нь гэрээ байгуулсан өдрөөс хойш 12 сарын хугацаанд үйл ажиллагаа эхлүүлээгүй бол;

16.4.3.паркийн нэгж нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн боловч дараалсан 24 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа нь тасалдсан, зогссон бол;

16.4.4.энэ хуулийн 12.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол.

⁵Хөрөнгө оруулалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 41 дугаарт нийтлэгдсэн.

16.5.Энэ хуулийн 16.4.1, 16.4.2, 16.4.3, 16.4.4-т заасан нөхцөл байдал нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан бий болсон бол паркийн нэгж нь татварын зарлагыг буцаан төлөхгүй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

17 дугаар зүйл. Паркийн үйл ажиллагаанд хориглох зүйл

17.1. Паркт дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

17.1.1. согтууруулах ундааны үйлдвэрлэл;
17.1.2. тамхины үйлдвэрлэл;
17.1.3. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын үйлдвэрлэл;

17.1.4. хуулиар хориглосон химийн хорт, цацраг идэвхт бодис ашиглах үйлдвэрлэл;

17.1.5. байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх боломжгүй үйл ажиллагаа;

17.1.6. хуулиар хориглосон бусад үйл ажиллагаа.

17.2. Паркийн удирдлага паркийн нэгжтэй ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

18 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль⁶, эсхүл Зөрчлийн тухай хуульд⁷ заасан хариуцлага хүлээлгэнэ.

19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

19.1. Энэ хуулийг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

⁶Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

⁷Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2009 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу олгосон паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд уг хугацааг сунгахгүй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй паркийн удирдлага нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гурван сарын дотор төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээг шинэчлэн байгуулах бөгөөд тус хуулийн дагуу шаардах аливаа мэдээллийг энэ зүйлд заасан хугацаанд багтаан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3 дугаар зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тус хуульд зөвшөөрсөн хуулийн этгээдийн хэлбэрээс бусад хуулийн этгээдийн хэлбэрээр өмнө нь паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцох бөгөөд хуулийн этгээдийн хэлбэрийг энэ хуульд нийцүүлж өөрчлөн зохион байгуулж шинээр тусгай зөвшөөрөл авна.

4 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдахаас өмнө паркийн үйл ажиллагаатай холбоотойгоор төлсөн татвар, хураамж нь уг хуульд заасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахгүй.

5 дугаар зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг эшилсэн холбогдох заалтуудыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр үйлчилж эхлэх буюу 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.1.16 дахь заалт нэмсүгэй:

“16.1.16.үйлдвэрлэл, технологийн паркийн газар.”

2 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “16.1.11” гэсний дараа “,16.1.16” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “16.1.14” гэсний дараа “,16.1.16” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь заалтын “16.1.12” гэсний дараа “,16.1.16” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“20.1.5.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу нутаг дэвсгэр, байршлыг тогтоох.”

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ХУУЛЬ ОРОЛГОХ

01000 ирмэг 05 КШН-ийн 110-д багтсан
Хуульчилсан үйлчилгээний үйлчилгээний байр

Зөвхөн ирмэг бүхий үйлчилгээний үйлчилгээний байр

6 КШН-ийн 110-д багтсан ирмэг бүхий үйлчилгээний үйлчилгээний байр
Хуульчилсан үйлчилгээний үйлчилгээний байр

« 2022 оны 07 сарын 05 » -н өдөр /Хуульчилсан үйлчилгээний үйлчилгээний байр/

1) КШН-ийн 110-д багтсан ирмэг бүхий үйлчилгээний үйлчилгээний байр
« 2022 оны 07 сарын 05 » -н өдөр /Хуульчилсан үйлчилгээний үйлчилгээний байр/

2) КШН-ийн 110-д багтсан ирмэг бүхий үйлчилгээний үйлчилгээний байр
« 2022 оны 07 сарын 05 » -н өдөр /Хуульчилсан үйлчилгээний үйлчилгээний байр/

3) КШН-ийн 110-д багтсан ирмэг бүхий үйлчилгээний үйлчилгээний байр
« 2022 оны 07 сарын 05 » -н өдөр /Хуульчилсан үйлчилгээний үйлчилгээний байр/

4) КШН-ийн 110-д багтсан ирмэг бүхий үйлчилгээний үйлчилгээний байр
« 2022 оны 07 сарын 05 » -н өдөр /Хуульчилсан үйлчилгээний үйлчилгээний байр/

Хуульчилсан үйлчилгээний үйлчилгээний байр
Хуульчилсан үйлчилгээний үйлчилгээний байр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУльд ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.8 дахь заалтын “80 000-200 000 төгрөг,” гэснийг “15 000 000-20 000 000 төгрөг,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Хуульчилсан үсэг

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль 2022 оны 07 сарын 05-ны өдөр

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.8 дахь заалтын “80 000-200 000 төгрөг,” гэснийг “15 000 000-20 000 000 төгрөг,” гэж өөрчилсүгэй.

Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9/үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрыг эхний 10 жилд газрын төлбөрөөс чөлөөлнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Хүчин төгөлдөр болсон өдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

Хүчин төгөлдөр болсон өдөр

7 дүгээр зүйл. Газрын төлбөрөөс чөлөөтэй байх үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрыг эхний 10 жилд газрын төлбөрөөс чөлөөлнө.

«9/үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрыг эхний 10 жилд газрын төлбөрөөс чөлөөлнө.»

10 дүгээр зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хүчин төгөлдөр болсон өдөр

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ИННОВАЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Инновацийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “12 дугаар зүйлд” гэснийг “17.1-д” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Урьдчилж заруулах

Хийсгэнэгийн үеэр 2020 оны 09 сарын 09 - 10-ны өдөр

Инновацийн тухай хуулийн 21.3 дугаар хэсгийг өөрчлөх тухай
Инновацийн тухай хуулийн 21.3 дугаар хэсгийг өөрчлөх тухай

6 сарын 06-ны өдөр .. Инновацийн тухай хуулийн 21.3 дугаар хэсгийг өөрчлөх тухай
.. Инновацийн тухай хуулийн 21.3 дугаар хэсгийг өөрчлөх тухай

7 сарын 07-ны өдөр .. Инновацийн тухай хуулийн 21.3 дугаар хэсгийг өөрчлөх тухай
.. Инновацийн тухай хуулийн 21.3 дугаар хэсгийг өөрчлөх тухай

Инновацийн тухай хуулийн 21.3 дугаар хэсгийг өөрчлөх тухай
Инновацийн тухай хуулийн 21.3 дугаар хэсгийг өөрчлөх тухай



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
ХОТ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.3 дахь хэсэг нэмсүгэй:

“7.3.үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх эд хөрөнгийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас эхний 5 жилд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.”

2 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠒᠐᠒᠒ оны ᠐7 дугаар сарын ᠐5 өдөр

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠤᠨ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийн “Хадгаламжийн даатгалын корпораци,” гэсний дараа “Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Хуульчилсан үсэг

Хуульчилсан үсэг /Хуульчилсан үсэг - 100 - /

Хуульчилсан үсэг /Хуульчилсан үсэг - 100 - /

Хуульчилсан үсэг /Хуульчилсан үсэг - 100 - /

Хуульчилсан үсэг /Хуульчилсан үсэг - 100 - /

Хуульчилсан үсэг /Хуульчилсан үсэг - 100 - /

Хуульчилсан үсэг /Хуульчилсан үсэг - 100 - /



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/38 дугаар зүйлийн 38.1.20 дахь заалт:

“38.1.20.энэ хуулийн 40.4-т заасны дагуу татвар төлөх хугацааг сунгасан хугацаанд үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмж.”

2/40 дүгээр зүйлийн 40.4, 40.5 дахь хэсэг:

“40.4.Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.

40.5.Энэ хуулийн 38.1.20, 40.4-т заасныг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Бусад талуудын талаар

Бусад талуудын талаар

2020 он 09 сарын 09 - 2020 он 09 сарын 09

Талуудын талаар : Талуудын талаар
Талуудын талаар

6 сарын 09 - 2020 он 09 сарын 09 : Талуудын талаар
Талуудын талаар

2020 он 09 сарын 09 - 2020 он 09 сарын 09

« 2020 он 09 сарын 09 - 2020 он 09 сарын 09 »
Талуудын талаар

2020 он 09 сарын 09 - 2020 он 09 сарын 09

« 2020 он 09 сарын 09 - 2020 он 09 сарын 09 »
Талуудын талаар

2020 он 09 сарын 09 - 2020 он 09 сарын 09

2020 он 09 сарын 09 - 2020 он 09 сарын 09
Талуудын талаар

Талуудын талаар : Талуудын талаар
Талуудын талаар



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай
10.29 дүгээр зүйл нэмсүгэй:

“10.29 дүгээр зүйл.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих

1.Паркийн удирдлага нь хуулиар хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Паркийн нэгж нь хуулиар хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Зөвшөөрөгчдийн хурал

᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 - ᠒᠐᠒᠒ оны
07 сарын 05 өдөр

Хурлын дарга
Г.Занданшатар

᠖. ᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр
᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр

᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр
᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр

᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр
᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр

᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр
᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр

᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр
᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр

᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр
᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр

᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр
᠒᠐᠒᠒ оны 07 сарын 05 өдөр

Зөвшөөрөгчдийн хурал
Г.Занданшатар



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь хэсгийн “10.27,” гэсний дараа “10.29,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬНЫ ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬНЫ ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬНЫ ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬНЫ ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬНЫ ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠦᠨᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ
ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ

ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ

ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ
ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ
ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ

ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ
ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ
ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ
ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ
ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ

ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ

ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠨᠢᠯᠢᠨ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар
хот

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-г даалгасугай:

1/паркийн үйл ажиллагаанаас төсөвт төвлөрөх орлогын тодорхой хувьтай тэнцэх санхүүжилтийг паркийг хөгжүүлэх, түүний дэд бүтцийг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зориулалтаар жил бүрийн улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авч, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

2/үйлдвэрлэл, технологийн паркийн хууль, эрх зүйн зохицуулалт, татварын орчны талаарх танилцуулга, сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Б.Чойжилсүрэн/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 07 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хаянхярваагийн Амгаланбаатар, Төмөр-Очирын Батзул нарын чөлөөлөгдөх хүсэлтийг үндэслэн даатгуулагчийг төлөөлсөн, Хуягийн Ганбаатарын бүрэн эрхийн хугацаа нь дууссан тул ажил олгогчийг төлөөлсөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Хуягийн Буянжаргал, Бархасын Баяраа нарыг даатгуулагчийг төлөөлсөн, Рэнцэндоржийн Сансармааг ажил олгогчийг төлөөлсөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр тус тус томилсугай.

3.Энэ тогтоолыг 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Зөвлөх Сүхбаатарын Хүрэл

ТТ0101
Хар 09 Км-ийн 50 - 0
Км-ийн 010
Хиймэл даатгалын үндэсний зөвлөл

Хүрэл Ганзориг, Хуягийн Буянжаргал, Бархасын Баяраа нарыг даатгуулагчийг төлөөлсөн, Рэнцэндоржийн Сансармааг ажил олгогчийг төлөөлсөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр тус тус томилсугай.

Хүрэл Ганзориг, Хуягийн Буянжаргал, Бархасын Баяраа нарыг даатгуулагчийг төлөөлсөн, Рэнцэндоржийн Сансармааг ажил олгогчийг төлөөлсөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр тус тус томилсугай.

Хүрэл Ганзориг, Хуягийн Буянжаргал, Бархасын Баяраа нарыг даатгуулагчийг төлөөлсөн, Рэнцэндоржийн Сансармааг ажил олгогчийг төлөөлсөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр тус тус томилсугай.

Хүрэл Ганзориг, Хуягийн Буянжаргал, Бархасын Баяраа нарыг даатгуулагчийг төлөөлсөн, Рэнцэндоржийн Сансармааг ажил олгогчийг төлөөлсөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр тус тус томилсугай.

Хүрэл Ганзориг, Хуягийн Буянжаргал, Бархасын Баяраа нарыг даатгуулагчийг төлөөлсөн, Рэнцэндоржийн Сансармааг ажил олгогчийг төлөөлсөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр тус тус томилсугай.

Хүрэл Ганзориг, Хуягийн Буянжаргал, Бархасын Баяраа нарыг даатгуулагчийг төлөөлсөн, Рэнцэндоржийн Сансармааг ажил олгогчийг төлөөлсөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр тус тус томилсугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 03 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Оросоогийн Нарангэрэлийг Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 03 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Словени Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ганхуурайн Баттунгалагийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Словени Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Мижиддоржийн Цэнгэгийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 1 дүгээр
сарын 5-ны өдөр

Дугаар 8

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Улсын аварга малчин, улсын хошой аварга малчин шалгаруулах журам”-ыг 1 дүгээр хавсралт, Улсын аварга фермер шалгаруулах журам”-ыг 2 дугаар хавсралт, “Улсын аварга саальчин шалгаруулах журам”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2.Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Улсын аварга тариаланч хамт олон, Улсын аварга тариаланч шалгаруулах журам”-д дор дурдсан агуулгатай 2.1.11-2.1.15, 3.4.8 дахь дэд заалт тус тус нэмсүгэй:

“2.1.11.Тариалангийн тухай хуулийн 25.1-д заасан хөрс хамгаалах, сайжруулах үйл ажиллагаа болон ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлсэн байх;

2.1.12.хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлсэн байх, аж ахуйн нэгж нь хөдөө аж ахуйн инженер, агрономичтой байх;

2.1.13.талбайн түүх хөтөлсөн байх, ургамлын гарал үүсэл, бүртгэл хяналтын систем (www.plant.mofa.gov.mn)-д бүртгүүлсэн байх;

2.1.14.статистик мэдээллийг цаг тухайд нь сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасаг, холбогдох бусад байгууллагуудад хүргүүлж мэдээллийн нэгдсэн системд оруулсан байх;

2.1.15.тариалангийн талбайд ойн зурвас байгуулсан байх.

3.4.8.тариалангийн талбайн хөрсний агрохими, агрофизикийн үзүүлэлтийг тодорхойлсон лабораторийн шинжилгээг сүүлийн 3 жилийн аль нэгд нь хийлгэж, цахим мэдээллийн санд оруулсан байх.”

3.Мөн журмын 2.1.6 дахь дэд заалтын “хамгаалах,” гэсний дараа “тариалангийн талбайд ойн зурвас байгуулах,” гэж, 4.1 дэх заалтын “туг,” гэсний дараа “мөнгөн аяга,” гэж тус тус нэмсүгэй.



4.Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 5 дугаар тогтоолын 3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.Малын тоог бэлчээрийн даацад тохируулан бэлчээрийг зохистой ашигласан, малын тоо толгойн албан татвар төлсөн, малын чанарыг сайжруулж нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлсэн, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа бүрэн хамруулсан, тогтвортой, ухаалаг газар тариалан эрхлэх замаар эрүүл чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн малчин, саальчин, фермер, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн нийгэмд оруулж байгаа хувь нэмэр зэрэг шалгуур үзүүлэлтээр үнэлэн, орон нутагтаа тэргүүлсэн малчин, саальчин, фермер, тариаланч хамт олон, тариаланчийг шалгаруулан шагнаж урамшуулж байхыг аймаг, сумын Засаг дарга нарт, фермерийг шалгаруулан шагнаж урамшуулж байхыг нийслэл, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.”

5.Улсын аварга малчин, улсын хошой аварга малчин, улсын аварга фермер, улсын аварга саальчин, улсын аварга тариаланч хамт олон, улсын аварга тариаланчийг шагнахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

6.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 5 дугаар тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

З.МЭНДСАЙХАН

Засгийн газрын 2022 оны 8 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН АВАРГА МАЛЧИН, УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, мал маллагааны уламжлалт аргыг түгээн дэлгэрүүлж залуу үедээ уламжлуулах, малын үүлдэрлэг байдал чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх, малыг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулах, малчдын нийгэмд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Энэ журамд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан малчны ажлын үзүүлэлтийг үндэслэн Улсын аварга, Улсын хошой аварга малчнаар тус тус шалгаруулна.

1.3.Улсын аварга малчин, улсын хошой аварга малчинд шагнал олгох шийдвэрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар гаргана.

Хоёр.Шагналд тодорхойлогдох малчинд тавигдах шаардлага

2.1.Улсын аварга малчнаар шагнуулахаар тодорхойлогдох малчин нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.мал сүргээ жилийн дөрвөн улиралд уламжлалт аргаар өөрөө малладаг, мал маллагааны туршлагаа залуу малчдад зааж сургаж шавь малчинтай болсон, орон нутагт ажлын байр бий болгож ядуурлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулсан байх;

2.1.2.өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржааны хашаатай, доройтсон бэлчээрийг сайжруулах, худаг гаргах, булаг, шандны эхийг хамгаалахад хөрөнгө оруулалт хийсэн байх;

2.1.3.сумын тухайн жилийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг сэлгэх, өнжөөх, отор хийх зэргээр даацыг хэтрүүлэхгүйгээр ашигладаг, өвөл, хаврын улирлын бэлчээр ашиглах гэрээ байгуулсан, бэлчээрийн хортон мэрэгч, шавжтай тэмцэх зэрэг бэлчээр хамгааллын ажилд оролцдог байх;



2.1.4.жил бүрийн мал өвөлжилт, хаваржилтад бэлтгэх өвс, тэжээлийн нийт хэмжээ нь нэг хонин толгойд өндөр уулын бүсэд 20 кг, ойт хээрийн бүсэд 50 кг, тал хээрийн бүсэд 40 кг, говийн бүсэд 5 кг-аас багагүй байх;

2.1.5.тухайн бүс нутгийн байгаль, цаг уурын онцлог тохирсон төрөл, үүлдэр, омгийн малыг өсгөн үржүүлдэг, малын чанарыг сайжруулж, сүргийн зохистой бүтцийг бүрдүүлсэн байх;

2.1.6.жил бүр үржлийн малдаа үзлэг ангилалтыг технологит хугацаанд хийлгэсэн байх;

2.1.7.үржлийн малыг ялган тэмдэглэж малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлжүүлсэн, үржлийн малын удам гарваль, ашиг шимийн чиглэл тодорхой байх;

2.1.8.Стандарт хэмжил зүйн газраас батлагдсан Монгол хонь, ямааны стандартын шаардлага хангасан бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлдэг байх;

2.1.9.хээлтэгчийн сүрэгт эзлэх хувийн жин бог малд 55, бод малд 40 болон түүнээс дээш хувьд хүрсэн, бодод шилжүүлснээр 100-аас доошгүй толгой малтай байх;

2.1.10.сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэн сүрэгт эзлэх таваарын малын 40-өөс доошгүй хувийг жил бүр эдийн засгийн эргэлтэд оруулсан байх;

2.1.11.мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа тогтмол, бүрэн хамруулж, малын эрүүл мэндийн дэвтэр хөтөлдөг, сүүлийн 3 жилд мал сүрэгт нь малын гоц халдварт болон халдварт өвчин гараагүй, малын зүй бус хорогдолгүй байх;

2.1.12.малчин нь малын тоо толгойн албан татварыг тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоосон хэмжээгээр бүрэн төлсөн байх;

2.1.13.малчин нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд даатгуулж, малын индексжүүлсэн даатгалд малаа даатгуулсан байх.

2.2.Малчны малын тоо, зах зээлд нийлүүлсэн бүтээгдэхүүний дүнд сүүлийн 1 жилд бусдаас худалдаж болон бэлгэнд авсан мал, бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй.

Гурав.Улсын аварга малчин, улсын хошой аварга малчин шалгаруулах

3.1.Сумын Засаг даргын Тамгын газар нь аймгийн аварга малчнаар шалгарснаас хойш 3-аас доошгүй жил амжилтаа бататгасан, энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангаж байгаа тус бүр нэг малчныг улсын аварга малчнаар шалгаруулахаар тодорхойлно. Тодорхойлсон малчин нь энэ журмын шаардлагыг хангасан тухай нотлох баримт бичгийг хүснэгт 2-т заасны дагуу бүрдүүлэн багийн Иргэдийн Нийтийн Хурлын шийдвэр, сумын Засаг даргын тодорхойлолтын хамт аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.2.Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сумдаас улсын аварга малчин, улсын хошой аварга малчинд тодорхойлж ирүүлсэн малчны холбогдох баримт бичгийг хянаж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хамгийн өндөр үзүүлэлттэй 3 хүртэлх малчны тодорхойлолтыг жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.3.Энэ журмын 3.2-т зааснаас бусад аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сумдаас энэ журмын 3.1-д заасны дагуу ирүүлсэн баримт бичгийг хянаж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2.1-д заасан шаардлагыг хамгийн сайн хангасан 8 хүртэлх малчны тодорхойлолтыг жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4.Улсын хошой аварга малчнаар тодорхойлж байгаа малчны ажлын үзүүлэлтийг сүүлийн 5 жилээр гаргана.

3.5.Сумын Засаг даргын Тамгын газар нь улсын аварга малчнаар шалгарснаас хойш 5-аас доошгүй жил амжилтаа бататгасан, энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангаж байгаа малчныг улсын хошой аварга малчнаар тодорхойлон аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.6.Аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сумдаас улсын хошой аварга малчнаар тодорхойлсон малчдын баримт бичгийг хянаж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн журмын 2.1-д заасан шаардлагыг хамгийн сайн хангасан малчныг энэ журмын 3.2-т заасан аймгаас 3 жил тутамд 1, бусад аймгаас жил бүр 1 малчны тодорхойлолтыг 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.7.“Улсын аварга малчин”-аар жил бүр 100 хүртэлх, “Улсын хошой аварга малчин”-аар 8 хүртэлх тооны малчныг шалгаруулна.

3.8.Тэмээ голлон өсгөж байгаа 1 малчныг жил бүр улсын аварга малчнаар шалгаруулна.

3.9.Улсын аварга малчин, улсын хошой аварга малчинд тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна:

3.9.1.малчны товч анкет (Хүснэгт 1);

3.9.2.холбогдох тодорхойлолт, баримт бичиг (Хүснэгт 2);

3.9.3.малчны ажлын үзүүлэлт (Хүснэгт 3-4).

3.10.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймгуудаас ирүүлсэн малчдын тодорхойлолтыг хянаж, дүгнэлт гарган журмын шаардлагыг хамгийн сайн хангасан малчдыг улсын аварга малчин, улсын хошой аварга малчнаар шалгаруулахаар саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

3.11.Энэ журам батлагдахаас өмнө Улсын сайн малчин, Улсын аварга малчин өрх, Улсын хошой аварга малчин өрхөөр шагнагдсан малчныг Улсын аварга малчин, Улсын хошой аварга малчинтай адилтган үзнэ.

Дөрөв.Шагнал олгох

4.1.Улсын аварга малчин, Улсын хошой аварга малчин тус бүрийг дурсгалын цом, мөнгөн аяга, гуулин бүслүүртэй модон хувин, өргөмжлөл, энгэрийн тэмдэг, үнэмлэх, бусад зүйлсээр 4.0 (дөрвөн) сая төгрөгт багтаан шагнах, улаан халз бүхий таван ханатай гэр худалдан авахад шаардагдах зардлыг тухайн жилийн улсын төсөвт тусгаж шагнаж болно.

4.2.Улсын аварга малчин, Улсын хошой аварга малчинд олгох цом нь 30 см өндөртэй, 32 см өргөнтэй, өлзий болон цэцгэн хээгээр чимэглэсэн ширээ хэлбэрийн суурьтай, бадамлянхуа цэцгэн хээ бүхий тавцантай, их биеийн дээд хэсэгт алтан соёмбо, төв хэсэгт төрийн сүлд байршуулсан, доод хэсэгт нь Улсын аварга малчин, Улсын хошой аварга малчин гэсэн бичвэрийг тухайн оны хамт товойлгон бичиж, их биеийн ар талыг түмэн насан хээгээр чимэглэж “Монгол Улсын Засгийн газраас дурсгав.” гэсэн байна.




4.3.Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрөөс өмнө гардуулна.

4.4.Улсын аварга малчин, Улсын хошой аварга малчны шагнал гардуулах ажлыг Засгийн газрын гишүүд нэгдсэн байдлаар зохион байгуулж аварга малчныг алдаршуулна.

---o0o---

Хүснэгт 1



**УЛСЫН АВАРГА МАЛЧИН, УЛСЫН ХОШОЙ АВАРГА
МАЛЧИНД ТОДОРХОЙЛЖ БАЙГАА МАЛЧНЫ
ТОВЧ АНКЕТ**

..... онсар..... өдөр

1.	Аймаг, сум, багийн нэр	
2.	Ургийн овог	
3.	Эцгийн (эх) нэр	
4.	Нэр	
5.	Төрсөн он, сар, өдөр	
6.	Хүйс	
7.	Нас	
8.	Боловсрол	
9.	Ам бүлийн тоо	
10.	Улсад ажилласан жил	
11.	Малчнаар ажилласан жил	
12.	Сумын аварга малчны үнэмлэхийн дугаар, огноо	
13.	Аймгийн аварга малчны үнэмлэхийн дугаар, огноо	
14.	Шагнагдсан төрийн одон, медаль, огноо	

---o0o---



**УЛСЫН АВАРГА МАЛЧИН, УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИНД
ТОДОРХОЙЛОГДСОНАЙМАГ.....СУМЫН МАЛЧНЫ
ТОДОРХОЙЛОЛТ, БАРИМТ БИЧИГ**

..... он..... сар..... өдөр

Улсын аварга малчин, Улсын хошой аварга малчинд тодорхойлж байгаа малчин дараах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ:

1.Малчны ажил байдлын тодорхойлолт;
2.Иргэний үнэмлэхийн хуулбар;
3.Малын А дансны хуулга Улсын аварга малчинд тодорхойлсон бол сүүлийн 3 жилээр, Улсын хошой аврага малчинд тодорхойлсон бол сүүлийн 5 жилээр;

4.Сумын аварга малчны үнэмлэхийн хуулбар;
5.Аймгийн аварга малчны үнэмлэхийн хуулбар;
6.Улсын хошой аварга малчинд тодорхойлох тохиолдолд Улсын аварга малчны үнэмлэхийн хуулбар;

7.Малын тоо толгойн албан татвар төлсөн тухай цахим лавлагаа;
8.Малчны нийгмийн даатгал төлсөн тухай цахим лавлагаа;
9.Малчны эрүүл мэндийн даатгал төлсөн тухай цахим лавлагаа;
10.Малын индексжүүлсэн даатгалын гэрээний хуулбар, мөнгө төлсөн баримт;

11.Малчин үржлийн малдаа үзлэг ангилалт хийлгэсэн тухай сумын Хөдөө аж ахуйн тасгийн тодорхойлолт;

12.Малчин малаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулсан тухай сумын Мал эмнэлгийн тасгийн тодорхойлолт;

13.Багийн иргэдийн Нийтийн Хурлын тэмдэглэл;
14.Сумын Засаг даргын албан хүсэлт;
15.Аймгийн ХХААГазрын шалгаруулалт хийсэн тухай дүгнэлт;
16.Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр, Засаг даргын албан хүсэлт;

17.Малын тоо толгойн албан татвар тогтоосон тухай сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын тогтоолын хуулбар.

---o0o---



Хүснэгт 3

УЛСЫН АВАРГА МАЛЧИНД ТОДОРХОЙЛЖ БАЙГАА АЙМГИЙН СУМЫН
..... БАГИЙН МАЛЧИН-НЫ-НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Малын үлдэр, омог:
Тэмээ Адуу Үхэр
Хонь Ямаа

2.1. Сүргийн бүтэц

Он	Оны эхний мал						Хээлтэгч						Хээлтүүлэгч						Бойжуулсан төл						
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа	Бүгд	Бүүр	Азарга	Бүх	Хуц	Үхна	Бүгд	Ботго	Үнага	Тугал	Хурга	Ишиг	
2019																									
2020																									
2021																									

2.1 Малын зарлага (үргэлжлэл)

Он	Зах зээлд борлуулсан мал						Үржилд худалдсан мал						Малжуулахад өгсөн мал						Зүй бусаар хорогдсон мал						
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа	Бүгд	Бүүр	Азарга	Бүх	Хуц	Үхна	Бүгд	Ботго	Үнага	Тугал	Хурга	Ишиг	
2019																									
2020																									
2021																									

2.1. Малын зарлага (үргэлжлэл)

Он	Өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн мал						Оны эцэст тоологдсон мал						Оны эцэст байгаа хээлтэгч					
	Бүтд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүтд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүтд	Ингэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа
2019																		
2020																		
2021																		

2.1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл (үргэлжлэл)

Он	Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл						Мах үйлдвэрлэлийн хэмжээ (кг)						Амьд мал борлуулснаас олсон орлого (мян.төг)					
	Тэмээний ноос (кг)	Хонинь ноос (кг)	Яманы ноос (кг)	Мах ноолуур (кг)	Үйлдвэрлэл (кг)	Сүү (л)	Хонинь мах (кг)	Яманы мах (кг)	Үхрийн мах (кг)	Адууны мах (кг)	Тэмээний мах (кг)	Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ	Хонь	Ямаа
2019																		
2020																		
2021																		

2.1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл (үргэлжлэл)

Он	Мал аж ахуйн бүтээгдэхүүн боловруулснаас олсон орлого (мян.төг)						Цагаан идээ											
	Махнаас	Хонинь ноос	Тэмээний ноос	Ноолуур	Сүү	Арьс ширнээс	Цагаан идээ	Цагаан идээ	Цагаан идээ	Цагаан идээ	Цагаан идээ	Цагаан идээ						
2019																		
2020																		
2021																		



2.1. Татвар, даатгал, хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Он	Бэлтгэсэн			Хашаа, худаг				Хөрөнгө оруулалт (мян.төг)				Татвар төлөлт				Малын даатгалд хамрагдсан байдал	
	Өвс (кг)	Тэжээл (кг)	Хүжир шүү (кг)	Хашааны тоо	Багтаамж, хонин толгойгоор	Хүдгийн тоо	Хүчин чадал (г.сек)	Худар	Малын хашаа, хороо	Бэлчээр сайжруулах	Хадлангийн талбай хамгаалах	Малын тоо толгойн татвар (мян.төг)	Эрүүл мэндийн даатгалд, (мян.төг)	Нийгмийн даатгалд, (мян.төг)	Бусад татвар, (мян.төг)	даатгуулсан малын тоо	Төлсөн шимтгэл
2019																	
2020																	
2021																	

Хүснэгт 4

УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИНД ТОДОРХОЙЛЖ БАЙГАА АЙМГИЙН
..... СУМЫН БАГИЙН МАЛЧИН -НЫ
..... -НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Малын үүлдэр, омог: Тэмээ Адуу Үхэр Хонь Ямаа

Он	Оны эхний мал					2.1. Сүргийн бүтэц					Хээлтүүлэгч					Бойжуулсан төл									
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа	Бүгд	Бур	Азагга	Бух	Хуц	Ухна	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг	
2017																									
2018																									
2019																									
2020																									
2021																									



2.1.Малын зарлага (үргэлжлэл)

Он	Зах зээлд борлуулсан мал						Үржилд худалдсан мал						Малжуулахад өгсөн мал						Зүй бусаар хорогдсон мал						
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
2017																									
2018																									
2019																									
2020																									
2021																									

2.1.Малын зарлага (үргэлжлэл)

Он	Өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн мал						Оны эцэст тоологдсон мал						Оны эцэст байгаа хээлтэгч					
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Ннгэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа
2017																		
2018																		
2019																		
2020																		
2021																		

2.1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл (үргэлжлэл)

Он	Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл					Мах үйлдвэрлэлийн хэмжээ (кг)							Амьд мал борлуулснаас олсон орлого (мян.төг)				
	Тэмээний ноос (кг)	Хонины ноос (кг)	Ямааны ноолуур (кг)	Мах үйлдвэрлэл (кг)	Сүү (л)	Хонины мах (кг)	Ямааны мах (кг)	Үхрийн мах (кг)	Адууны мах (кг)	Тэмээний мах (кг)	Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ		
2017																	
2018																	
2019																	
2020																	
2021																	

2.1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл (үргэлжлэл)

Он	Мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулснаас олсон орлого (мян.төг)						
	Махнаас	Хонины ноос	Тэмээний ноос	Ноолуур	Сүү	Арьс ширнээс	Цагаан идээ
2017							
2018							
2019							
2020							
2021							



2.1.Татвар, даатгал, хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Он	Бэлтгэсэн			Хашаа, худаг			Хөрөнгө оруулалт (мян.төг)			Татвар төлөлт				Малын даатгалд хамрагдсан байдал			
	Өвс (кг)	Тажээл (кг)	Хужир шүү (кг)	Хашанья тоо	Баттамж, хонин толгойгоор	Хүдгийн тоо	Хүчин чадал (л.сек)	Худар	Малын хашаа, хороо	Бэлчээр сайжруулах	Хадлангийн талбай хамгаалах	Малын тоо толгойн татварт (мян. төг)	Эрүүл мэндийн даатгалд (мян.төг)	Нийгмийн даатгалд, (мян.төг)	Бусад татварт, (мян.төг)	даатгуулсан малын тоо	Төлсөн шимтгэл
2017																	
2018																	
2019																	
2020																	
2021																	

Засгийн газрын 2022 оны 8 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

“УЛСЫН АВАРГА ФЕРМЕР” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Өндөр ашиг шимт мал, амьтан өсгөн үржүүлж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлж байгаа эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийг урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Энэ журамд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан эрчимжсэн аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг үндэслэн Улсын аварга фермерээр шалгаруулна.

1.3.Улсын аварга фермерээр шалгаруулан шагнах шийдвэрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар гаргана.

Хоёр.Фермерт тавигдах шаардлага

2.1.Улсын аварга фермерээр шагнуулахаар тодорхойлох эрчимжсэн аж ахуй эрхлэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа эрхэлж, орчны ариун цэвэр, эрүүл ахуй, халдваргүйжилтийг шийдвэрлэсэн, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх;

2.1.2.мал, амьтныг эрсдэлээс хамгаалах даатгалд хамруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл тогтмол төлсөн байх;

2.1.3.гоц халдварт болон халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа бүрэн хамруулж, мэргэжлийн байгууллагаар эрүүл сүрэгтэйгээ баталгаажуулсан байх;

2.1.4.мал бүрийг ээмэгжүүлж, бүртгэлжүүлсэн, үржилд ашиглаж байгаа малын анги, ашиг шимийн гарц, чанарыг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байх;



2.1.5. мал үржлийн алба болон хэрэглэгчийн захиалгаар үржлийн мал, амьтан бойжуулж, нийлүүлсэн байх;

2.1.6. эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа туршлагаа залуу малчдад эзэмшүүлэх талаар санаачилга гарган ажиллаж 3-аас доошгүй ажлын байр шинээр бий болгосон байх.

Гурав. Эрчимжсэн аж ахуй эрхлэгч фермерт тавих шалгуур үзүүлэлт

3.1. Улсын аварга фермерээр шагнуулахаар тодорхойлох эрчимжсэн аж ахуй эрхлэгч нь энэ журмын 2.1-д заасан шаардлагаас гадна дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

3.1.1. өндөр ашиг шимт нэг үүлдрийн мал, амьтныг сонгон үржүүлдэг, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний хэмжээ жил дараалан өссөн байх;

3.1.2. тухайн үүлдрийн мал, амьтны арчилгаа маллагааны технологи, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, тоног төхөөрөмжтэй байх;

3.1.3. эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг байх;

3.1.4. мал, амьтны чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанар сайжруулах чиглэлээр шинэ техник, тоног төхөөрөмж, дэвшилтэт арга технологи нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалт хийж, тодорхой үр дүнд хүрсэн байх;

3.1.5. саалийн болон махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч иргэн 20-оос доошгүй га, аж ахуйн нэгж 100-аас доошгүй га газрыг хашиж хамгаалан ногоон тэжээл тариалдаг байх;

3.1.6. үржилд ашиглаж байгаа мал, амьтан бүрийн удам гарваль, ашиг шимийн бүртгэл хөтөлж мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан тухай баталгаа, үржлийн удам гарвалын гэрчилгээг сумын Хөдөө аж ахуйн тасгаас авсан байх;

3.1.7. өвлийн улиралд саалийн хугацаанд саамын гарцыг тодорхойлж мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан, үндэсний үйлдвэрлэлд нийлүүлсэн байх;



3.1.8.махны үхрийн аж ахуй эрхэлж байгаа иргэн 100, аж ахуйн нэгж 200-аас доошгүй үнээтэй, оны эхний нэг үхрээс 50 кг-аас доошгүй мах үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн махны хэмжээ жил дараалан өссөн байх;

3.1.9.махны чиглэлийн хонь үржүүлж байгаа иргэн 300, аж ахуйн нэгж 500-аас доошгүй эм хоньтой, оны эхний нэг хониноос 7.5 кг-аас доошгүй мах үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн махны хэмжээ жил дараалан өссөн байх;

3.1.10.гахайн аж ахуй эрхэлж байгаа иргэн 10, аж ахуйн нэгж 60-аас доошгүй үндсэн мэгжтэй, мэгж бүрээс жилд 20-оос доошгүй торой бойжуулж, мах үйлдвэрлэл нь жил дараалан өссөн байх;

3.1.11.өндөглөгч шувуу үржүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж нь оны эхэнд 25000-аас доошгүй өндөглөгчтэй, нэг өндөглөгчөөс жилд 280-аас доошгүй өндөг үйлдвэрлэсэн байх;

3.1.12.жилийн эхний байдлаар зөгийн аж ахуй эрхэлж байгаа иргэн 40, аж ахуйн нэгж нь 120-аас доошгүй бүл зөгийтэй байх ба нэг бүлээс 20 кг-аас доошгүй зөгийн бал үйлдвэрлэсэн байх.

3.2.Мал, гахай, шувуу, зөгийн бүлийн тоо, бүтээгдэхүүний дүнд бусдаас худалдан авсан болон өр төлбөр, бэлгэнд авсан мал, гахай, шувуу, зөгийн бүл, бүтээгдэхүүнийг тооцохгүй.

Дөрөв.Шагналд тодорхойлох, шалгаруулах

4.1.Сумын Засаг даргын Тамгын газар аймаг, нийслэлийн аварга фермерээр шалгарснаас хойш гурваас доошгүй жил амжилтаа тогтвортой хадгалан ажиллаж энэ журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан фермерийг сум, дүүргээс Улсын аварга фермерээр тодорхойлж баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн шийдвэр, сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт, хүсэлтийн хамт аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.2.Аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сум, дүүргээс ирүүлсэн тодорхойлолт, холбогдох баримт бичгийг хянаж шаардлага хангасан хамгийн өндөр үзүүлэлттэй нэг фермерийн тодорхойлолтыг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийн хамт жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.



4.3. Улсын аварга фермерээр шалгаруулахаар тодорхойлохдоо дараах баримт бичиг бүрдүүлсэн байна:

- 4.3.1. фермерийн анкет (Хүснэгт 1-ийн дагуу);
- 4.3.2. ажлын үзүүлэлтүүд (Хүснэгт 2-4-ийн дагуу);
- 4.3.3. ажлын үзүүлэлт, тодорхойлолт (Хүснэгт 5-ын дагуу).

4.4. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Улсын аварга фермерээр шалгаруулахаар бүрдүүлж ирүүлсэн тодорхойлолт, материалыг хянан үзэж, шаардлагатай тохиолдолд газар дээр нь шалгаж дүгнэлт гаргана.

4.5. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан хамгийн өндөр үзүүлэлт бүхий 9 хүртэл эрчимжсэн аж ахуй эрхлэгч фермерийн тодорхойлолт, холбогдох материалыг шалгаруулж саналаа зохих журмын дагуу Засгийн газарт хүргүүлнэ.

4.6. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийг Улсын аварга фермерээр зөвхөн нэг удаа шалгаруулна.

4.7. Энэ журам батлагдахаас өмнө нь Улсын тэргүүний фермер болж байсан фермерийг Улсын аварга фермертэй адилтган үзэх бөгөөд дахин шагнахгүй.

Тав. Шагнал олгох

5.1. Улсын аварга фермерийг 5.0 (таван сая) төгрөгт багтаан дурсгалын цом, мөнгөн аяга, гуулин бүслүүртэй модон хувин, өргөмжлөл, энгэрийн тэмдэг, үнэмлэх, бусад зүйлээр шагнана.

5.2. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрөөс өмнө гардуулна.

---o0o---



Хүснэгт 1

Цээж зураг
/6x4/
өнгөт

**УЛСЫН АВАРГА ФЕРМЕРТ ТОДОРХОЙЛОХ
ИРГЭНИЙ ТОВЧ АНКЕТ**

..... онсар..... өдөр

1.	Аймаг, сум, багийн нэр	
2.	Ургийн овог (эхнэр, нөхөр)	
3.	Эцгийн (эх) нэр	
4.	Нэр	
5.	Төрсөн он, сар, өдөр, нас, хүйс	
6.	Боловсрол	
7.	Ам бүлийн гишүүдийн тоо	
8.	Улсад ажилласан жил	
9.	Үүнээс фермерээр ажилласан жил	
10.	Сумын аварга фермерээр шалгарсан үнэмлэхийн дугаар огноо	
11.	Аймаг, нийслэлийн тэргүүний болон аварга фермерээр шалгарсан он, үнэмлэхийн дугаар огноо	
12.	Шагнагдсан төрийн одон, медаль, огноо	



**УЛСЫН АВАРГА ФЕРМЕРТ ТОДОРХОЙЛОХ АЖ АХУЙН
НЭГЖИЙН ТОВЧ АНКЕТ**

.....он.....сар..... өдөр

1.	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр	
2.	Аж ахуйн нэгжийн нэр	
3.	Байгуулагдсан он, сар, өдөр	
4.	Үйл ажиллагааны чиглэл	
5.	Боловсон хүчний мэдээлэл	
6.	Энэ үйл ажиллагаа явуулж байгаа хугацаа	
7.	Аймаг, нийслэлийн тэргүүний болон аварга фермерээр шалгарсан он, үнэмлэхийн дугаар	
8.	Шагнагдсан төрийн одон, медаль, огноо	

Хүснэгт 2

**УЛСЫН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛОХАЙМАГ
(НИЙСЛЭЛ)-ИЙНСУМ (ДҮҮРЭГ)-ЫН СҮҮНИЙ ҮХРИЙН
АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ -НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ**

.....он.....сар... өдөр

Үзүүлэлт	Онууд		
 он он он
1. Үржүүлж байгаа үхрийн үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт үхэр (тоо)			
Үүнээс: а/ үнээ (тоо)			
б/ бусад			
в/ бойжуулсан тугал (тоо)			
3. Үйлдвэрлэсэн нийт сүү (тонн)			
4. Саалийн 305 хоногт нэг үнээнээс саасан сүү (литр)			
5. Үржилд худалдсан үхрийн тоо			
Үүнээс: а/ өсвөр хээлтүүлэгч			
б/ өсвөр хээлтэгч			
6. Бүртгэлд авч баталгаажуулсан цөм сүргийн малын тоо			
7. Зохиомлоор хээлтүүлсэн үнээний тоо			
8. Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тонн)			



Үүнээс: өөрийн хүчээр бэлтгэсэн: а/ хүчит тэжээл (тонн)			
б/ дарш (тонн)			
в/ өвс (тонн)			
9. Тэжээлийн ургамал тариалсан нийт талбайн хэмжээ (га)			
а/ хураан авсан нийт тэжээлийн ургамал (цн)			
б/ нэг га-гаас авсан ургац (цн)			
10. Нэг үхэрт зарцуулсан тэжээлийн хэмжээ (тэжээлийн нэгж)			
11. Үхрийн байрны багтаамж (м ²)			
12. Ашиглаж байгаа худгийн хүчин чадал (литр/сек)			
13. Оны эцэст тоологдсон нийт үхэр			
Үүнээс: үнээ (тоо)			
14. Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг)			
15. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
16. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
17. Малчны дундаж цалин (мян.төг)			
18. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			

-----сум (дүүрэг)-ын Засаг дарга ----- /...../

Хөдөө аж ахуйн тасгийн дарга ----- /...../

Хүснэгт 3

**УЛСЫН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛОХ
АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН.....СУМ (ДҮҮРЭГ)-ЫН МАХНЫ
ҮХЭР (ХОНЬ)-ИЙН АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ-НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ**

.....онсар өдөр

Үзүүлэлт	Онууд		
 он он он
1. Үржүүлж байгаа үхэр (хонь)-ийн үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт үхэр, эсхүл хонины тоо			
Үүнээс: а/ хээлтэгч (тоо)			
б/ хээлтүүлэгч (тоо)			
в/ бойжуулсан төл (тоо)			
3. Үйлдвэрлэсэн нийт мах (тонн)			
4. Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах (кг), (нядалгын жингээр)			
5. Зах зээлд борлуулсан нэг үхэр, эсхүл хонины дундаж амьдын жин (кг)			
6. Үржилд худалдсан нийт үхэр, эсхүл хонины тоо			
Үүнээс: а/ өсвөр хээлтүүлэгч			
б/ өсвөр хээлтэгч			
7. Бүртгэлд авч баталгаажуулсан цөм сүргийн тоо			



8. Зохиомлоор хээлтүүлсэн малын тоо			
9. Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
Үүнээс: а/ өөрийн хүчээр бэлтгэсэн тэжээл (тонн)			
б/ худалдаж авсан тэжээл (тонн)			
10. Тэжээлийн ургамал тариалсан нийт талбайн хэмжээ (га)			
11. Хураан авсан нийт тэжээлийн ургамал (цн)			
12. Нэг га-гаас авсан ургац			
13. Нэг малд зарцуулсан тэжээлийн хэмжээ (тэжээлийн нэгж)			
14. Хашааны багтаамж (м ²)			
15. Худгийн хүчин чадал (литр/сек)			
16. Оны эцэст тоологдсон нийт мал			
Үүнээс: а/ хээлтэгч (тоо)			
б/ хээлтүүлэгч (тоо)			
17. Хөрөнгө оруулалт (мян.төг)			
18. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
19. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
20. Нэг ажилтны дундаж цалин (мян.төг)			
21. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			

-----сум (дүүрэг)-ын Засаг дарга ----- /...../

Хөдөө аж ахуйн тасгийн дарга ----- /...../

Хүснэгт 4

**УЛСЫН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛОХ
АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН.....СУМ (ДҮҮРЭГ)-ЫН ГАХАЙ, ШУВУУ,
ЗӨГИЙН АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ-НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ**

.....он.....сар..... өдөр

Үзүүлэлт	Онууд		
 он он он
Нэг. Гахайчны ажлын үзүүлэлт			
1. Үржүүлж байгаа гахайн үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт гахайны тоо			
Үүнээс: а/ үндсэн мэгжийн тоо			
б/ үржилд ашиглах бодонгийн тоо			
в/ бойжуулсан нийт торойн тоо			
г/ нэг мэгжнээс бойжуулсан торой			
3. Үйлдвэрлэсэн нийт гахайн мах (тонн)			
4. Маханд борлуулсан нэг гахайн дундаж амьдын жин (кг)			
5. Үржилд худалдсан мэгжний тоо			
6. Оны эцэст тоологдсон нийт гахай			
Үүнээс: үндсэн мэгжийн тоо			
7. Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
Үүнээс: а/ өөрийн хүчээр үйлдвэрлэсэн (тонн)			



б/ худалдан авсан тэжээл (тонн)			
8. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
9. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
10. Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг)			
11. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			
Хоёр. Шувуучны ажлын үзүүлэлт			
1. Үржүүлж байгаа шувууны үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт шувууны тоо			
Үүнээс: өндөглөгч шувууны тоо			
3. Нийт үйлдвэрлэсэн өндөг (мян.ширхэг)			
Үүнээс: борлуулсан өндөг (мян.ширхэг)			
4. Бойжуулсан дэгдээхэй			
5. Үржилд худалдсан шувуу			
6. Үйлдвэрлэсэн мах (кг)			
7. Эх сүргийн шувууны тоо			
8. Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
Үүнээс: а/ өөрийн хүчээр бэлтгэж, үйлдвэрлэсэн (тонн)			
б/ худалдан авсан тэжээл (тонн)			
9. Оны эцэст байгаа нийт шувуу			
Үүнээс: өндөглөгч шувууны тоо			
10. Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг)			
11. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
12. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
13. Нэг ажилчны дундаж цалин (мян.төг)			
14. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			
Гурав. Зөгийчний ажлын үзүүлэлт			
1. Үржүүлж байгаа зөгийн үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт зөгийн бүлийн тоо			
3. Нийт үйлдвэрлэсэн зөгийн бал (тонн)			
Үүнээс: а/ борлуулсан зөгийн бал (тонн)			
б/ нэг бүлээс хураасан дундаж зөгийн балны хэмжээ (кг)			
4. Үржүүлсэн бүлэнцэр			
5. Үржилд худалдсан зөгийн бүл			
6. Жилд шаардагдах зөгийн тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
Үүнээс: а/ өөрийн зөгийн балаар тэжээсэн хэмжээ (тонн)			
б/ Худалдан авсан зөгийн тэжээлийн хэмжээ (тонн)			
7. Оны эцэст байгаа нийт зөгийн бүл			
8. Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг)			
9. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
10. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
11. Нэг ажилчны дундаж цалин (мян.төг)			
12. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			

Тайлбар: Үзүүлэлтийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар шалгаж баталгаажуулна.

----- сум (дүүрэг)-ын Засаг дарга ----- /...../

Хөдөө аж ахуйн тасгийн дарга ----- /...../

Хүснэгт 5

**УЛСЫН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛОХАЙМАГ
(НИЙСЛЭЛ)-ИЙН СУМ (ДҮҮРЭГ)-ЫН
..... ТОДОРХОЙЛОЛТ**

1. Фермерийн ажил байдлын тодорхойлолт;
2. Фермерийн мал, амьтны А дансны хуулга сүүлийн 3 жилээр;
3. Иргэний үнэмлэхийн хуулбар;
4. Сум, дүүргийн аварга фермерийн үнэмлэхийн хуулбар;
5. Аймаг, нийслэлийн тэргүүний болон аварга фермерийн үнэмлэхийн хуулбар;
6. Мал, амьтны эрүүл мэндийн дэвтрийн хуулбар;
7. Өрхийн гэр бүлийн гишүүдийн нийгмийн даатгал төлсөн тухай цахим лавлагаа;
8. Өрхийн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн даатгал төлсөн тухай цахим лавлагаа;
9. Малын тоо, толгойн албан татвар төлсөн тухай цахим лавлагаа;
10. Малын индексжүүлсэн даатгалын гэрээний хуулбар, мөнгө төлсөн баримт;
11. Сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасгийн тодорхойлолт;
12. Сум, дүүргийн Мал эмнэлгийн тасгийн тодорхойлолт;
13. Баг, хорооны иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэл, шийдвэр;
14. Сум, дүүргийн Засаг даргын албан хүсэлт;
15. Аймаг, нийслэлийн ХХААГазрын шалгаруулалт хийсэн тухай албан бичиг;
16. Аймаг, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр, Засаг даргын албан хүсэлт;
17. Малын тоо толгойн албан татвар тогтоосон тухай сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын тогтоолын хуулбар.

---о0о---

Засгийн газрын 2022 оны 8 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

УЛСЫН АВАРГА СААЛЬЧИН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Мал аж ахуйн үйлдвэрлэлд тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж, хээлтэгч малаа саалинд бүрэн хамруулж, өрхийн үйлдвэрлэлээр хамгийн их сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байгаа саальчны хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Энэ журмын шаардлагыг хангасан саальчны ажлын үзүүлэлтийг нь үндэслэн улсын аварга саальчнаар шалгаруулна.

1.3.Улсын аварга саальчин шагнал олгох шийдвэрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар гаргана.

Хоёр.Шагналд тодорхойлоход тавигдах шаардлага

2.1.Улсын аварга саальчнаар тодорхойлох саальчин дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.сүүлийн жилүүдэд тухайн малчин оны эхэнд байсан мал нь бодод шилжүүлснээр 100-аас доошгүй байх бөгөөд 100 хээлтэгчээс бойжуулсан төлийн тоо улсын дунджаас илүү байх;

2.1.2.тухайн саальчны мал сүрэгт эзлэх хээлтэгч мал бог малд 55, бод малд 40-өөс доошгүй хувь байх;

2.1.3.төллөсөн бүх хээлтэгчийг саалинд бүрэн хамруулж, нийт саасан сүүний хэмжээ жил дараалан өссөн байх;

2.1.4.нэг хээлтэгчээс сааж байгаа сүү нь тухайн орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омгийн малын ашиг шимийн дундаж үзүүлэлтээс дээгүүр байх, сүү, цагаан идээгээ зах зээлд борлуулсан байх;

2.1.5.мэргэжлийн байгууллагаас ангилалт хийж удам гарваль, ашиг шимийг нь тогтоосон, стандартын шаардлага хангасан малыг үржилд ашигладаг, малаа сумын мал эмнэлэг, үржлийн тасгийн бүртгэлд хамруулсан байх;

2.1.6.ой хээрийн бүсэд хонин толгойд шилжүүлснээр нэг малд 50 кг, өндөр уулын бүсэд 20 кг, тал хээрийн бүсэд 40 кг, говийн бүсэд

5 кг-аас доошгүй өвстэй тэнцэхүйц хадлан, гар тэжээл, өвсөн дарш, хүчит тэжээлийг жил бүр бэлтгэж нөөцөлсөн байх;

2.1.7.мал саах, саалиа боловсруулах арга ажиллагаагаа зааж сурган шавь саальчинтай болсон байх;

2.1.8.мал сүргээ эрүүл байлгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан байх;

2.1.9.бэлчээрийн даацад малынхаа тоог тохируулж, сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу хуваарьтай ашиглаж бэлчээр хамгаалах арга хэмжээ авдаг байх;

2.1.10.мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжээр үржлийн малдаа жил бүр ангилалт хийлгэсэн байх;

2.1.11.таваарын малын 30-аас доошгүй хувийг жил бүр эдийн засгийн эргэлтэд оруулсан байх;

2.1.12.өөрийн ашиглаж байгаа бэлчээрт хортон мэрэгч, шавжтай энгийн механик болон микробиологийн аргаар тэмцсэн байх;

2.1.13.өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа, малын хашаа, саравч, худагтай байх.

2.2.Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу татвараа төлсөн байх.

2.3.Улсын аварга саальчинд эрчимжсэн аж ахуй эрхэлж буй саальчныг тодорхойлохгүй.

Гурав.Аварга саальчнаар тодорхойлох, шалгаруулах

3.1.Саальчнаар 25-аас доошгүй жил ажилласан байх, аймгийн аварга саальчин болсноос хойш гурваас доошгүй жил амжилттай ажилласан, энэ журамд заасан шаардлага, ажлын үзүүлэлтийг хангасан 1 саальчныг тухайн сумын Засаг даргын Тамгын газраас улсын аварга саальчнаар шалгаруулахаар тодорхойлж, багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн шийдвэр, сумын Засаг даргын тодорхойлолтын хамт аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.2.Аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сумаас улсын аварга саальчинд тодорхойлж ирүүлсэн саальчны холбогдох баримт бичгийг хянан үзээд аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хамгийн өндөр үзүүлэлттэй нэг хүртэл саальчны тодорхойлолтыг жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.3.Улсын аварга саальчнаар тодорхойлохдоо дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна:

3.3.1.саальчны товч анкет (Хүснэгт 1-ийн дагуу);

3.3.2.холбогдох байгууллагын тодорхойлолт (Хүснэгт 2-ын дагуу);

3.3.3.ажлын үзүүлэлт (Хүснэгт 3-ын дагуу).

3.4.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Улсын аварга саальчин болгохоор тодорхойлон аймгаас ирүүлсэн саальчдын материалыг саальчин нэг бүрээр хянан, харьцуулсан дүгнэлт гаргаж, энэ журамд заасан шаардлага, ажлын үзүүлэлтийг хангасан, хамгийн өндөр үзүүлэлт бүхий 6 хүртэлх саальчныг шалгаруулж саналаа Засгийн газарт хүргүүлнэ.

Дөрөв.Шагнал олгох

4.1.Улсын аварга саальчин тус бүрийг 4.0 (дөрвөн) сая төгрөгт багтаан дурсгалын цом, мөнгөн аяга, гуулин бүслүүртэй модон хувин, өргөмжлөл, энгэрийн тэмдэг, үнэмлэх, бусад зүйлээр шагнана.

4.2.Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрөөс өмнө гардуулна.

---o0o---

Хүснэгт 1

УЛСЫН АВАРГА СААЛЬЧНААР ТОДОРХОЙЛОХ ХҮНИЙ ТОВЧ АНКЕТ

.....он.....сар..... өдөр

1.	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр	
2.	Ургийн овог	
3.	Эцэг (эх)-ийн нэр	
4.	Нэр	
5.	Төрсөн он, нас, хүйс	
6.	Боловсрол	
7.	Ам бүлийн гишүүдийн тоо	
8.	Улсад ажилласан жил	
9.	Үүнээс: саальчнаар ажилласан жил	
10.	Төр, засгаас авсан шагнал, огноо	
11.	Аймаг, нийслэлийн аварга саальчнаар шалгарсан он, үнэмлэхийн дугаар	



Хүснэгт 2

**УЛСЫН АВАРГА СААЛЬЧНААР ТОДОРХОЙЛОХ
АЙМГИЙН.....СУМЫН-ЫН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ,
ТОДОРХОЙЛОЛТ**

Улсын аварга саальчинд тодорхойлж байгаа саальчин дараах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ:

- 1.Саальчны ажил байдлын тодорхойлолт (шилдэг арга туршлага);
- 2.Өрхийн малын А дансны хуулга сүүлийн 3 жилээр;
- 3.Иргэний үнэмлэхийн хуулбар;
- 4.Сумын аварга саальчин цолны үнэмлэхийн хуулбар;
- 5.Аймгийн аварга саальчин цолны үнэмлэхийн хуулбар;
- 6.Малын эрүүл мэндийн дэвтрийн хуулбар;
- 7.Өрхийн гэр бүлийн гишүүдийн нийгмийн даатгал төлсөн баримт (цахим лавлагаа);
- 8.Өрхийн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн даатгал төлсөн баримт (цахим лавлагаа);
- 9.Малын индексжүүлсэн даатгалын гэрээ болон даатгал төлсөн баримтын хуулбар;
- 10.Малын тоо, толгойн албан татвар төлсөн тухай цахим лавлагаа;
- 11.Сумын Хөдөө аж ахуйн тасгийн тодорхойлолт (ангилалт, хашаа, хороо, өвс, тэжээл, ашиг шим);
- 12.Сумын Мал эмнэлгийн тасгийн тодорхойлолт (угаалга, тарилга, туулга хамрагдалт);
- 13.Багийн иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэл, шийдвэр;
- 14.Сумын Засаг даргын албан хүсэлт;
- 15.Аймгийн ХХААГазрын шалгаруулалт хийсэн тухай дүгнэлт, албан бичиг;
- 16.Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр, Засаг даргын албан хүсэлт;
- 17.Малын тоо толгойн албан татвар тогтоосон тухай сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлын тогтоолын хуулбар.

-оОо-

Хүснэгт 3

“УЛСЫН АВАРГА СААЛЫЧИН”-Д ТОДОРХОЙЛЖ БАЙГАА АЙМГИЙНСУМЫН
СААЛЫЧИН-НЫ-НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Сүргийн бүтэц

Он	Оны эхний мал			Үүнээс: хээлтэгч			Хээлтэгчийн эзлэх хувь					
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа
2019												
2020												
2021												

2.1. Ашиг шим (үргэлжлэл)

Он	Нэг хээлтэгчээс саасан сүү (литр)			Нийт саасан сүү (литр)						
	Ингэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа	Ингэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа
2019										
2020										
2021										

2.1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл (үргэлжлэл)

Он	Нэр төрөл			Борлуулалтын орлого (мян.төг)									
	Ааруул (кг)	Эзгий (кг)	Аарц (кг)	Өрөм, зөөхий (кг)	Айраг (литр)	Хоормог (литр)	Бүгд	Ааруул	Эзгий	Аарц	Өрөм, зөөхий	Айраг	Хоормог
2019													
2020													
2021													



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 1 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Амьтны тухай хуулийн 5.2.4, 7.6-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2.Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 93 дугаар тогтоол, “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 9 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Засгийн газрын 2022 оны 19 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

АГНУУР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Амьтны тухай хуулийн 21.4-т заасан агнуурын нөөцийг хамгаалах зорилго бүхий мэргэжлийн байгууллага (цаашид “мэргэжлийн байгууллага” гэх)-ын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд аймгийн болон агнуурын бүс нутгийн агнуур зохион байгуулалт, агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, зөвлөмж өгөх үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөл ажиллана.

1.3.Мэргэжлийн зөвлөлийн дүрэм, агнуур зохион байгуулалтын судалгааны аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Мэргэжлийн зөвлөлийн зөвлөмжийг харгалзан агнуурын менежментийн төлөвлөгөөг баталж, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Амьтны тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан цахим мэдээллийн санд байршуулна.

1.5.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах агнуурын бүс нутгийн агнуур зохион байгуулалтын тайлан, агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийнэ.

1.6.Нарийвчилсан агнуур зохион байгуулалтын судалгааг ховор амьтны агнуурын бүс нутагт 2 жил тутам, бусад агнуурын бүс нутагт 4 жил тутам мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

Хоёр.Агнуур зохион байгуулалтын төрөл

2.1.Агнуур зохион байгуулалт нь дараах төрөлтэй байна:

2.1.1.Ерөнхий агнуур зохион байгуулалт;

2.1.2.Нарийвчилсан агнуур зохион байгуулалт.

2.2.Ерөнхий агнуур зохион байгуулалтыг аймгийн нутаг дэвсгэр дэх тухайн зүйл амьтны тархац нутгийн 30-аас доошгүй хувьд хийж, тоо толгой, сүргийн бүтэц, нөхөн үржлийн чадавхыг судалсны үндсэн дээр агнуурын бүс нутгийн хил хязгаарыг тогтооно.

2.3.Нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг ерөнхий агнуур зохион байгуулалтын тайланд тусгасан агнуурын бүс нутгийн 80-аас доошгүй хувьд хийж, агнуурын бүс нутгийн хил хязгаар, агнуурын нөөцийг тогтоосон байна.

2.4.Агнуурын ховор амьтан хоёр ба түүнээс дээш сумын нутаг дэвсгэрийг дамнан тархсан тохиолдолд нарийвчилсан агнуур зохион байгуулалтын судалгааг сумын хилийн цэсээр хязгаарлахгүйгээр амьтны амьдралын үйл ажиллагаа хэвийн явагдах боломжтой талбайг бүхэлд нь хамруулан хийнэ.



2.5.Мэргэжлийн байгууллага нь агнуурын бүс нутгийн амьтны мониторинг судалгааны хөтөлбөрийг боловсруулж, орон зайн болон тоон мэдээллийг нэгтгэн дүгнэж, цахим мэдээллийн санд байршуулна.

Гурав.Агнуур зохион байгуулалтын үе шат

3.1.Агнуур зохион байгуулалтыг дараах үе шаттайгаар явуулна:

3.1.1.бэлтгэл ажил;

3.1.2.хээрийн хайгуул судалгаа;

3.1.3.хээрийн хайгуул судалгааны үр дүнг боловсруулах, захиалагчид хүлээлгэн өгөх.

3.2.Бэлтгэл ажлын хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

3.2.1.агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах;

3.2.2.агнуур зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах;

3.2.3.агнуурын бүс нутгийг гэрээгээр эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулах.

3.3.Хээрийн хайгуул судалгаа хийх ажлын хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

3.3.1.нарийвчилсан агнуур зохион байгуулалтын хээрийн судалгааг 5 жил тутам 2-оос доошгүй удаа хийж дүгнэлт гаргах;

3.3.2.агнуурын бүс нутаг дахь амьтны зүйлийн бүрдэл, агнуурын үндсэн зүйлийн биологийн болон агнуурын нөөц, жилд ашиглах боломжтой тоо, хэмжээ, нөхөн үржих чадавх, сүргийн бүтэц, байршил, тархац нутгийг тогтоох;

3.3.3.агнуурын амьтны идэш тэжээлийн нөөц, амьдрах орчинд тархсан бусад голлох зүйл амьтны элбэгшлийн байдлыг үнэлэх;

3.3.4.аймгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, нөхөрлөлийн оролцоотой гүйцэтгэх.



3.4.Хээрийн хайгуул судалгааны үр дүнг боловсруулах, захиалагчид хүлээлгэн өгөх ажлын хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

3.4.1.хээрийн хайгуул судалгааны явцад цуглуулсан мэдээ, мэдээллийг энэ журмын 1.3-т заасан аргачлал болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйг ашиглан боловсруулах;

3.4.2.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Амьтны тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан амьтны цахим мэдээллийн санд нээлттэй байршуулсан ховор амьтны мониторинг судалгааны мэдээллийг нэгтгэж, ерөнхий болон нарийвчилсан агнуур зохион байгуулалтын тайлан, төлөвлөгөөнд тусгах;

3.4.3.агнуурын бүс нутгийн хил хязгаараас 100 км зайд шинээр агнуурын бүс нутаг байгуулах тохиолдолд агнуурын улмаас амьтны үндсэн популяцид үүсэх сөрөг нөлөөллийг байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачлалаар тооцож, хамтарсан дүгнэлт гаргах ажлыг урьд нь байгуулагдсан агнуурын бүс нутгийн агнуур зохион байгуулалтыг хийсэн мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх.

3.5.Агнуурын бүс нутгийг тодорхойлохдоо дараах шалгуурыг харгалзан үзнэ:

3.5.1.амьтны үржлийн сүрэг тухайн байршилд 10 ба түүнээс дээш жилийн хугацаанд байнга байршиж, нүүдэл, шилжилт хийх боломжтой орон зайг хамарсан байх;

3.5.2.улсын тусгай хамгаалалттай газар нутагт амьтны жам ёсны эрх хөндөгдөх, үргээж дайжуулах, тоо толгойд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд тухайн зүйл ховор амьтны агнуурын бүс нутаг гурваас илүүгүй байх;

3.5.3.говь, хээрийн бүсийн ховор амьтны агнуурын бүс нутгийн хоорондын зай 80 километрээс доошгүй байх.

3.6.агнуур зохион байгуулалтын эхлэл, төгсгөлийн хэлэлцүүлгийг оролцогч талуудыг хамруулан зохион байгуулж дараах асуудлыг хэлэлцэнэ:

3.6.1.агнуур зохион байгуулалтын төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, агнуур зохион байгуулалттай холбоотой захиалагч болон бусад байгууллагын санал, хүсэлт;



3.6.2. агнуур зохион байгуулалтын тайлан, агнуурын менежментийн төлөвлөгөөний төсөл, менежмент хариуцагчийн гэрээний биелэлт.

3.7. Аймгийн агнуурын ерөнхий төлөвлөгөөний болон ховор амьтныг олзворын зориулалтаар агнах агнуурын бүс нутгийн агнуур зохион байгуулалтын тайлан, дүгнэлт, агнуурын менежментийн төлөвлөгөөний төслийг сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагаар хянуулж, саналыг тусгасны үндсэн дээр Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвлөмжийн хамт захиалагчид хүлээлгэн өгнө.

3.8. Ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтын болон загас агнуурын бүс нутгийн агнуур зохион байгуулалтын тайлан, агнуурын менежментийн төлөвлөгөөг аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагаар хянуулж захиалагчид хүлээлгэн өгнө.

Дөрөв.Бусад

4.1. Мэргэжлийн байгууллага нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгнө.

4.2. Агнуур зохион байгуулалтын судалгаа, агнуурын менежментийн төлөвлөгөөг аргачлалын дагуу хийгээгүй, судалгааны ажлын тоон мэдээллийг хуурамчаар гаргасан, холбогдох хууль, журмыг зөрчсөн тохиолдолд Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Засгийн газрын баталсан “Аж ахуй нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”-ын дагуу мэргэжлийн байгууллагын эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

4.3. Мэргэжлийн байгууллагын хийсэн агнуур зохион байгуулалтын судалгааны үр дүн, агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсний улмаас амьтны тоо толгой буурч, тархац, байршилд сөргөөр нөлөөлсөн бол хохирлыг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж, тухайн агнуур зохион байгуулалтыг хийсэн байгууллагаар нөхөн төлүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Засгийн газрын 2022 оны 19 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

ХОВОР АМЬТНЫГ АГНАХ, БАРИХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар амьтны цахим мэдээллийн санд үндэслэн ховор амьтан агнах, барих зөвшөөрлийг олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх) нь амьтны халдварт өвчнийг илрүүлэх, халдварын тархалтыг хязгаарлах болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ховор амьтныг агнах, барих зөвшөөрлийг албан бичгээр, бусад зөвшөөрлийг цахимаар олгоно.

1.3.Шаардлагатай тохиолдолд энэ журмын 1.2-т заасан зөвшөөрлийг олгох зорилгоор мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын санал, дүгнэлт гаргуулж болно.

1.4.Төв, суурин газрын болон амьтны тархац нутагтай ойр амьдарч буй хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдал, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, учирч болох эрсдэлээс зэрлэг амьтдыг хамгаалахтай холбоотой нөхцөл байдал үүссэн тохиолдолд аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, мэргэжлийн байгууллагатай хамтран ховор амьтныг барих удирдамжийг баталж, аюулгүй болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.5.Ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл хүсэх, амьтны цахим мэдээллийн санд өгөгдөл оруулах маягт, агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчийн гэрээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.6.Амьтны цахим мэдээллийн сан нь ховор амьтан агнах, барих зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулж, олон нийтэд нээлттэй, ан амьтны тоо толгой, тархац нутаг, нүүдэл, шилжилт хөдөлгөөний урт хугацааны мониторинг, судалгааны дүнг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

1.7.Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд ховор загас, голын экосистемийг хамгаалах, загас барих, загасчлалын отгийн үйлчилгээнд хяналт тавих үүргийг хамгаалалтын

захиргаа хэрэгжүүлэх бөгөөд энэ үүргийг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид гэрээний үндсэн дээр хариуцуулж болно.

Хоёр.Амьтны цахим мэдээллийн сан

2.1.Амьтны цахим мэдээллийн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ:

2.1.1.улсын хэмжээнд үнэлгээ хийсэн ховор амьтны тархац, нөөцийн судалгааны дүн, тухайн жилд агнах агнуурын амьтны тоо хэмжээг агнуурын бүс нутгаар хуваарилсан дэлгэрэнгүй мэдээлэл;

2.1.2.улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн зааг;

2.1.3.аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын тайланд тусгасан ховор амьтны тоо толгой, тархац, нөөц, агнуурын бүс нутгийн байршлын мэдээлэл;

2.1.4.аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан, дүгнэлт;

2.1.5.аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон нарийвчилсан агнуур зохион байгуулалтын тайлан, агнуурын бүс нутгийн хил хязгаар, талбайн хэмжээ;

2.1.6.агнуурын бүс нутгийн ховор амьтны тоо толгой, байршил, нөхөн үржил, төлжилт, сүргийн бүтэц, агнуурын нөөцийн мэдээ;

2.1.7.агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө болон тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, мэргэжлийн зөвлөлийн зөвлөмж;

2.1.8.агнуурын болон загасчлалын отгийн тэмдэглэл, олзворын мэдээлэл бүртгэх маягт.

2.2.Мэдээллийг энэ журмын 1.5-д заасан маягтын дагуу мэдээллийн санд байршуулна.

2.3.Төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.1.1, 2.1.2, 2.1.7-д заасан мэдээллийг цахим мэдээллийн санд оруулна.

2.4.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 2.1.3-2.1.5-д заасан мэдээллийг ерөнхий агнуур

зохион байгуулалт, аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд үндэслэн жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор батлагдсан маягтын дагуу цахим мэдээллийн санд оруулна.

2.5.Агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч нь ховор амьтны агнуурын бүс нутгийн нарийвчилсан агнуур зохион байгуулалтын судалгааг хоёр жил тутам, ховор загасны агнуурын бүс нутагт дөрвөн жилд нэг удаа мэргэжлийн байгууллагаар, туурайтай амьтны мониторинг судалгааг сар тутам, загасны мониторинг судалгааг загасчлалын хугацаанд хийж, энэ журмын 2.1.6, 2.1.8-д заасан мэдээллийг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор батлагдсан маягтын дагуу цахим мэдээллийн санд оруулна.

Гурав.Агнуурын бүс нутгийг тогтоох шалгуур үзүүлэлт

3.1.Тухайн жилд олзворын зориулалтаар ховор амьтан агнах агнуурын бүс нутаг дараах шалгуурыг хангасан байна:

3.1.1.аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тухайн агнуурын бүс нутаг тусгагдсан байх;

3.1.2.ховор амьтан агнуурын бүс нутагт хамгийн багадаа 10 жил тогтвортой байршсан байх;

3.1.3.агнуурын бүс нутагт ховор амьтны нөөц өсөлттэй, амьтны нийт тоо толгой 80-аас дээш байх;

3.1.4.агнуурын менежментийн төлөвлөгөө тухайн жилд 70-аас дээш хувь биелсэн байх.

3.2.Байгалийн аюулт үзэгдлийн улмаас ховор амьтад олноор хорогдсон нь Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон бол тухайн жилд агнах амьтны тоог менежментийн төлөвлөгөөнд заасан агнуурын нөөцийн тооноос бууруулж тогтооно.

3.3.Жилд агнах амьтны тоог бууруулан тогтоосон тохиолдолд менежмент хариуцагч жил бүр агнах агнуурын нөөцийг мэргэжлийн байгууллагаар өөрийн хөрөнгөөр тогтоолгож, тайланг орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагаар баталгаажуулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4.Тухайн жилд спорт загасчлалын зориулалтаар барих загас агнуурын бүс нутаг болон улсын тусгай хамгаалалттай газар дараах шалгуурыг хангасан байна:

3.4.1.ховор загасны нийт нөөц 100-аас дээш, жилд барих нөөц 50-аас дээш байх;

3.4.2.загас агнуурын менежментийн төлөвлөгөө нь тухайн агнуурын бүс нутаг байршиж байгаа тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөөтэй уялдсан байх;

3.4.3.загас агнуурын менежментийн төлөвлөгөө тухайн жилд 70-аас дээш хувь биелсэн байх.

Дөрөв. Ховор амьтан агнах, барих зөвшөөрөл олгох үйл ажиллагаа

4.1.Төрийн захиргааны төв байгууллага агнуурын бүс нутгийн нээлттэй цахим мэдээллийн санд үндэслэн дараа онд агнах, барих ховор амьтны тоо хэмжээний саналыг агнуурын бүс нутаг тус бүрээр гарган нэгтгэж, жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт хүргүүлнэ.

4.2.Засгийн газар дараа онд тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг баталснаас хойш ажлын 5 хоногт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тусгай зориулалтаар агнах, барих амьтны хуваарийг энэ журмын 1, 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бүрэн хуваарилан баталж, цахим мэдээллийн санд байршуулна.

4.3.Агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч энэ журмын 4.2-т заасан хуваарьт үндэслэн ховор амьтныг агнах, барих хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ.

4.4.Агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч ховор амьтан агнах зөвшөөрлийн цахим хүсэлтэд агнуурын нөөц ашигласны төлбөрийн урьдчилгаа 30 хувь, хураамжийг 100 хувь тухайн агнуурын бүс нутаг байрших сумын Төрийн сан дахь агнуурын нөөц ашигласны төлбөрийн дансанд төлөх бөгөөд олзворыг гадаадад гаргах хүсэлт гаргахаас өмнө төлбөрийн үлдэгдлийг бүрэн төлсөн байна.

4.5.Агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч тул загас барих зөвшөөрлийн цахим хүсэлтэд нэг удаагийн зөвшөөрөл нь 5 хоногт 1 тул, 10 хүртэл жижиг загас байхаар тооцож, агнуурын нөөц ашигласны төлбөр,



хураамжийг тухайн агнуурын бүс нутаг байрших сумын Төрийн сангийн агнуурын нөөц ашигласны төлбөрийн дансанд бүрэн төлнө.

4.6.Төрийн захиргааны төв байгууллага ховор амьтныг агнах, барих цахим хүсэлтийг ажлын 3 өдөрт багтаан хянаж зөвшөөрлийг олгоно.

4.7.Ховор амьтныг эрдэм шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнах, барих хүсэлтэд амьтны зүйлийн нэр, тоо толгой, үндэслэл, агнах болон барих арга зүй, хугацаа, аймаг, сум, агнуурын бүс нутгийн нэрийг тодорхой заана.

4.8.Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа энэ журмын 4.2-т заасан хуваарьт үндэслэн тусгай зориулалтаар загас барих гэрээг иргэн, хуулийн этгээдтэй жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор байгуулж, цахим мэдээллийн санд байршуулна.

4.9.Энэ журмын 4.8-д заасан гэрээнд улсын тусгай хамгаалалттай газар нутаг дахь ховор загасны амьдрах орчинд бүх төрлийн моторт завиар зорчихыг хориглох, отог байгуулах, мэргэжлийн хөтөч ажиллуулахтай холбоотой зохицуулалтыг тусгасан байна.

4.10.Ховор амьтан агнах, барих зөвшөөрлийг Амьтны тухай хуульд заасан агнах, барихыг зөвшөөрсөн хугацаанаас өмнө урьдчилан авч болох бөгөөд ховор амьтан агнах зөвшөөрлийн хүчинтэй хугацаа 14 хоног, ховор загас барих зөвшөөрлийн хугацаа 10 хүртэл хоног байна.

Тав.Агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчийн үйл ажиллагаа

5.1.Агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор аж ахуйн нэгж ховор амьтны агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчийн гэрээг төрийн захиргааны төв байгууллагатай, бусад агнуурын бүс нутгийн гэрээг сумын Засаг даргатай тав хүртэл жилийн хугацаатай байгуулна.

5.2.Аж ахуйн нэгж нь агнуурын болон байгалийн нөөцийн хамтын менежмент, аялал жуулчлалын чиглэлээр гурваас доошгүй жил ажилласан туршлагатай, амьтан судлал, агнуур зүйн чиглэлийн мэргэжлийн боловсон хүчин бүхий үндсэн ажилтантай байна.

5.3.Агнуурын менежментийн төлөвлөгөөний зарим үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаар туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж болох бөгөөд энэ нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.



5.4.Агнуурын бүс нутгийн агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн оролцоог хангаж, менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд жил бүр танилцуулж хамтран ажиллана.

5.5.Улсын тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд байршилтай агнуурын бүс нутгийн нарийвчилсан агнуур зохион байгуулалтын судалгаанд тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааг оролцуулна.

5.6.Агнуурын болон загасчлалын отгийн тохижилт, үйлчилгээний чанарыг холбогдох стандартад нийцүүлэн, нөхөрлөлийн гишүүдийг тогтмол мэргэшүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдүүлнэ.

5.7.Агнуурын ховор загасны амьдрах орчинд зөвхөн Амьтны тухай хуулийн 21.1.6-д заасан аргаар загасчилна.

5.8.Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд тусгай зориулалтын агнуур, агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар үнэн бодит, баталгаатай мэдээллийг түгээнэ.

5.9.Тусгай зориулалтаар амьтан агнах, барихдаа холбогдох хууль тогтоомжид хориглосон арга, хэрэгсэл ашигласан, эсхүл агнуурын бүс нутгийн хил хязгаараас гадна агнуур хийсэн, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн хугацааг зөрчсөн нь тогтоогдсон, агнуурын менежмент төлөвлөгөөг 2 жил дараалан хангалтгүй биелүүлсэн тохиолдолд менежмент хариуцагчийн гэрээг цуцална.

5.10.Агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч нь ховор амьтныг хамгаалахад шаардагдах хөрөнгө бий болгох зорилгоор агнуурын амьтны дуудлага худалдааг зохион байгуулж болно.

Зургаа.Бусад

6.1.Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд болон албан тушаалтанд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл
олгох журмын 1 дүгээр хавсралт

Маягт 1.

.... ОНД ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР АГНАХ ТОО ХЭМЖЭЭНИЙ ХУВААРЬ

Агнуурын бүс нутгийн харьяалал	Агнуурын бүс нутгийн нэр	Агнуурын бүс нутгийн шалгуур				Тусгай зориулалтаар агнах-ны тоо
		Аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан олноо	Агнуурын амьтны нийт тоо	Тухайн жилд агнах агнуурын нөөц	Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	
Аймаг	Сүм				



Ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл
олгох журмын 2 дугаар хавсралт

Маягт 2.

.... ОНД ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР БАРИХ ТОО ХЭМЖЭЭНИЙ ХУВААРЬ

№	Агнуурын бүс нутгийн харьяалал		Агнуурын бүс нутгийн нэр	Улсын тусгай хамгаалалттай газрын нэр	Шалгуур үзүүлэлт			Менежмент хариуцагчийн нэр	Загасчлалын зориулалтаар барьж, буцаан тавих тул загасны тоо
	Аймаг	Сум			Ховор загасны нөөц	Тухайн жилд барих загасны нөөц	Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь		
								



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 1 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 9^{1.3} дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Хүүхдийн мөнгөн хуримтлалыг Төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдсүгэй.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах, журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

Засгийн газрын 2022 оны 36 дугаар
тогтоолын хавсралт

ХҮҮХДИЙН МӨНГӨН ХУРИМТЛАЛЫГ ТӨРИЙН САНД БАЙРШУУЛАН ХУРИМТЛУУЛАХ, БҮРТГЭХ, МӨНГӨН ХЭЛБЭРЭЭР ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Ирээдүйн өв сангийн 2022 оны орлогоос Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн (цаашид “хүүхэд” гэх)-д хуримтлал үүсгэх, түүнийг бүртгэх, мөнгөн хэлбэрээр олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэ журмын 1.1-д заасан хүүхэд бүрд 2022 оны төсвийн жилд Ирээдүйн өв санд төвлөрөх орлогоос хуульд заасан хэмжээгээр хуримтлал үүсгэж, Төрийн санд байршуулан хуримтлуулна.

**Хоёр.Хүүхдийн мөнгөн хуримтлалд хамрагдах, хуримтлалыг
мөнгөн хэлбэрээр авах иргэний хүсэлтийг
хүлээн авах, хянан шийдвэрлэх**

2.1.Нийгмийн халамжийн нэгдсэн систем (цаашид “халамжийн систем” гэх)-д бүртгэлгүй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд, эсхүл 16 насанд хүрсэн бол хүүхэд өөрөө хүүхдийн мөнгөн хуримтлалд хамрагдах өргөдлийг сум, хорооны нийгмийн ажилтанд хандан өөрийн биеэр, эсхүл халамжийн системд хандан цахим хэлбэрээр гаргана.

2.2.Хүүхдийн мөнгөн хуримтлалд шинээр хамрагдах өргөдөл, өргөдөл гаргасан эцэг, эхийн иргэний үнэмлэх, хүүхдийн төрсний гэрчилгээг иргэнээс шаардахгүйгээр халамжийн системээс татан бүрдүүлж, уг системд байршуулах боломжгүй, нэмэлтээр шаардагдах баримт бичгийг цахим хэлбэрт хөрвүүлж, хавсаргана.

2.3.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн хүүхдийн мөнгөн хуримтлалд шинээр хамрагдах өргөдлийг халамжийн системээр дамжуулан цахимаар гаргаж болно.

2.4.Халамжийн системд энэ журам хүчин төгөлдөр болохоос өмнө бүртгэлтэй хүүхэд бүрийг мөнгөн хуримтлалд хамрагдах хүсэлт гаргасанд тооцно.

2.5.Энэ журмын 2.1-д заасны дагуу өргөдөл гаргахын өмнө арилжааны аль нэг банкийг сонгож, тухайн хүүхдийн нэр дээр данс нээлгэсэн байна.

2.6.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 91.4-т зааснаар хуримтлалыг мөнгөн хэлбэрээр авах тохиолдолд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд, эсхүл 16 насанд хүрсэн бол хүүхэд өөрөө хүсэлтээ дараах хэлбэрээс аль нэгийг сонгож, гаргана:

2.6.1.халамжийн системээр дамжуулан цахимаар;

2.6.2.Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем (ebarimt)-ээр дамжуулан цахимаар;

2.6.3.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (emongolia)-аар дамжуулан цахимаар;

2.6.4.сум, хорооны нийгмийн ажилтанд хандах;

2.6.5.арилжааны банканд хандах.

2.7.Энэ журмын 2.6-д заасан хүсэлтийг сар бүрийн 15-ны өдрийн дотор нэг удаа гаргах бөгөөд тухайн сард хүсэлт гаргахдаа дараагийн саруудын хуримтлалыг мөнгөн хэлбэрээр авах сонголтоо урьдчилж гаргаж болно.

2.8.Энэ журмын 2.6-д заасан хүсэлт гаргах эрх нь сар бүрийн 1-ний өдөр дахин сэргээгдэх бөгөөд өмнөх сард урьдчилж гаргасан сонголтыг өөрчилж болно. Хэрэв өмнөх сард хуримтлалыг мөнгөн хэлбэрээр авах хүсэлт гаргаагүй тохиолдолд нөхөн авах хүсэлтийг тухайн жилдээ багтаан гаргаж болно.

2.9.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхдийн төрөлжсөн асрамж, халамжийн төвд амьдарч байгаа хүүхдийн овог, нэр, регистрийн дугаар, арилжааны банканд дахь данс, шилжилт хөдөлгөөний мэдээллийг сар бүрийн 5-ны өдрийн дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.10.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага төрсний, нас барсны, үрчилсний, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэлд бүртгүүлсэн хүүхдийн регистрийн дугаар, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, байнга оршин суугаа хаягийн бүртгэлийн мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас авна.

2.11.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, иргэний харьяаллаа алдсан хүүхдийн мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас авна.

2.12.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн сарын хүүхдийн мөнгөн хуримтлал үүсгэх, түүнээс мөнгөн хэлбэрээр авах хүүхдийн нэрсийн жагсаалт, нийт шилжүүлгийн

хэмжээ болон өмнөх сарын хүүхдийн мөнгөн хуримтлалаас мөнгөн хэлбэрээр авах хүүхдийн нэрсийн жагсаалт, шилжүүлгийн дүнг цахимаар, нийт хүүхдийн тоо болон шилжүүлгийн хэмжээг албан бичгээр баталгаажуулж, сар бүрийн 18-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж (цаашид “Төрийн сангийн газар” гэх)-д хүргүүлнэ.

2.13.Энэ журмын 2.12-т заасан нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, нэгдмэл байдлыг Төрийн сангийн газар хариуцна.

2.14.Төрийн сангийн газар энэ журмын 2.12-т заасан мэдээллийн нийт мөнгөн дүн, тоо хэмжээ зөрчилгүй тохиолдолд банк хоорондын гүйлгээний системд боловсруулалтыг хийж төлбөрийг сар бүрийн 20-ны өдрийн дотор Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу гүйцэтгэнэ.

2.15.Төрийн сангийн газар хүүхдийн мөнгөн хуримтлалаас мөнгөн хэлбэрээр олгосон багцын гүйлгээний буцаалтыг ажлын 3 хоногийн дотор багц гүйлгээний системээр хүлээн авч, хүүхдийн хуримтлалын дансанд бүртгэн нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдээллийг цахимаар хүргүүлнэ.

2.16.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхдийн мөнгөн хуримтлал, түүнээс мөнгөн хэлбэрээр олгосон олголтыг бүртгэж, хүүхэд бүрээр нэгдсэн мэдээллийн сан үүсгэн төрийн сан дахь мөнгөн хуримтлалын дансны үлдэгдэлтэй сар бүрийн 30-ны өдрийн дотор тооцоо нийлэн баталгаажуулна.

Гурав.Хүүхдийн мөнгөн хуримтлалыг төрийн санд байршуулах, хүү тооцох

3.1.Төрийн сангийн газар төрийн сангийн нэгдсэн дансыг удирдах, мөнгөн хөрөнгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд Ирээдүйн өв сангийн батлагдсан төсвийн дагуу Хүүхдийн мөнгөн хуримтлалыг төрийн сангийн холбогдох дансанд байршуулан, хуримтлуулах бөгөөд хуримтлал төрийн сангийн дансанд байршсан хугацаанд Монголбанк, Сангийн яам хооронд байгуулсан “Төрийн сангийн төгрөгийн харилцах дансны үлдэгдэлд хүү төлөх гэрээ”-нд заасан хувь, хэмжээгээр хүү тооцож, жилийн эцэст олгоно.

3.2.Энэ журмын 3.1-д заасны дагуу тооцогдох хүүгийн зардлыг Монгол Улсын тухайн оны төсвийн тухай хуульд тусгасан хүүгийн зардлаас санхүүжүүлнэ.

**Дөрөв.Хүүхдийн мөнгөн хуримтлалыг бүртгэх,
мөнгөн хэлбэрээр олгох**

4.1.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхдийн мөнгөн хуримтлал болон мөнгөн хэлбэрээр олгосон олголтын мэдээллийг халамжийн системд хүүхэд тус бүрээр бүртгэл үүсгэнэ.

4.2.Хүүхэд 18 нас хүрэхэд энэ журмын 3.1-д заасан хүүхдийн мөнгөн хуримтлалыг тухайн хүүхдийн арилжааны банканд дахь нэрийн дансанд дараагийн сард шилжүүлнэ.

4.3.Энэ журмын 4.2-т заасан хугацаанаас өмнө хүүхэд нас барсан тохиолдолд энэ журмын 3.1-д заасан хүүхдийн мөнгөн хуримтлалыг тухайн хүүхдийн арилжааны банканд дахь нэрийн дансанд дараагийн сард шилжүүлнэ.

4.4.Энэ журмын 4.2-т заасан хугацаанаас өмнө хүүхэд Монгол Улсын харьяатаас гарсан тохиолдолд энэ журмын 3.1-д заасан хүүхдийн мөнгөн хуримтлалыг тухайн хүүхдийн арилжааны банканд дахь нэрийн дансанд дараагийн сард шилжүүлнэ.

4.5.Хүүхдийн мөнгөн хуримтлалд хамрагдах өргөдөл гаргасан бол тухайн сараас тооцож, хуримтлуулна.

4.6.Хүүхдийн мөнгөн хуримтлалаас мөнгөн хэлбэрээр авах хүсэлт гаргасан боловч тухайн иргэнээс үл хамаарах шалтгаанаар тухайн сардаа хуримтлалаас мөнгөн хэлбэрээр авч чадаагүй бол хүсэлтийг үндэслэн хуримтлалаас мөнгөн хэлбэрээр нөхөн олгоно.

4.7.Хүүхдийн мөнгөн хуримтлалд хамрагдах болон хуримтлалаас мөнгөн хэлбэрээр авах хүсэлтээ гаргасан боловч тухайн ондоо багтан дансанд нь ороогүй тохиолдолд нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь үүсгэх хуримтлал болон мөнгөн хэлбэрээр олгох дүнгээр өглөг үүсгэж, дараа оны төсвийн жилд нөхөн олгоно.



4.8.Хүүхдийн төрөлжсөн асрамж, халамжийн төвд амьдардаг хүүхдийн хуримтлалаас мөнгөн хэлбэрээр авах тохиолдолд асрамж, халамжийн төв нь хүүхдийг төлөөлөн хүсэлт гаргаж, тухайн хүүхдийн нэр дээрх хугацаатай хадгаламжийн дансанд шилжүүлэн авч болно. Хүүхдийн хадгаламжийн данснаас бэлэн мөнгөөр авахыг хориглоно.

4.9.Энэ журмын 4.8-д заасан данс нээлгэх ажлыг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага зохион байгуулна.

4.10.Хүүхдийн төрөлжсөн асрамж, халамжийн төвд амьдардаг хүүхдэд нээлгэсэн хадгаламжийн дэвтрийг тухайн асрамж, халамжийн төв хадгалж, хүүхдийг 16 нас хүрч иргэний үнэмлэх авсны дараа өөрт нь хүлээлгэн өгнө. Хэрэв хүүхэд нас барсан тохиолдолд хадгаламжийн дэвтрийг өв залгамжлагчид нь хууль тогтоомжид заасны дагуу хүлээлгэн өгнө.

4.11.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага нь энэ журмын 4.8, 4.9, 4.10-т заасан үйл ажиллагаанд хяналт тавина.

4.12.Харьяатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж хоёрдмол харьяалалтай болсон иргэний хүүхдэд хүүхдийн мөнгөн хуримтлал олгохгүй.

4.13.Энэ журмын 2.1-д заасан иргэн хүүхдийн мөнгөн хуримтлалаас мөнгөн хэлбэрээр авах дансыг нэгтгэн нэг дансаар авах хүсэлтэй бол арилжааны банкандаа хандаж дансаа холбуулж болно.

Тав.Хүүхдийн мөнгөн хуримтлал, түүнээс мөнгөн хэлбэрээр олгохыг зогсоох

5.1.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд хүүхдийн мөнгөн хуримтлалыг зогсоох шийдвэр гаргана:

5.1.1.хүүхэд 18 нас хүрсэн;

5.1.2.хүүхэд нас барсан;

5.1.3.хүүхэд Монгол Улсын харьяатаас гарсан;

5.1.4.өөрийн хүсэлтээр хүүхдийн мөнгөн хуримтлал

болон түүнээс мөнгөн хэлбэрээр авахаас татгалзсан;

5.1.5.хуурамч баримт бичиг бүрдүүлэн хүүхдийн мөнгөн хуримтлалаас мөнгөн хэлбэрээр авсан нь тогтоогдсон.

5.2.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд хуримтлалыг мөнгөн хэлбэрээр олгохыг түр зогсоох шийдвэр гаргана:

5.2.1.регистрийн дугаар давхардах болон өөр бусад шалтгаанаар хүүхдийн мөнгөн хуримтлалаас илүү олгогдсон;

5.2.2.эцэг, эх, асран хамгаалагч нь сураггүй алга болсон;

5.2.3.эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийн эрхийг зөрчсөн, хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ үл биелүүлсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн талаар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, эсхүл хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлт гарсан.

5.3.Энэ журмын 5.2.1-д заасан тохиолдол үүссэн бол дараа сарын мөнгөн олголтоос суутгана.

5.4.Энэ журмын 5.2.2-т заасны дагуу түр зогсоосон тохиолдолд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон харьяа сум, дүүргийн Засаг даргын захирамжийг үндэслэн хуримтлалыг мөнгөн хэлбэрээр олгохыг түр зогсоосон хугацаанаас тооцож үргэлжлүүлэн олгоно.

5.5.Энэ журмын 5.2.3-т заасны дагуу мөнгөн олголтыг түр зогсоосон тохиолдолд орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, эсхүл хүүхдийн эрхийн улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийг үндэслэн хуримтлалыг мөнгөн хэлбэрээр олгохыг түр зогсоосон хугацаанаас тооцож үргэлжлүүлэн олгоно.

Зургаа.Бусад

6.1.Сум, хорооны нийгмийн ажилтан иргэд, олон нийтийг хүүхдийн мөнгөн хуримтлалтай холбоотой мэдээллээр хангаж ажиллана.

6.2.Хүүхэд шинээр төрсөн, үрчлэгдсэн, нас барсан зэргээр тухайн гэр бүлд амьдарч байгаа хүүхдийн тоо өөрчлөгдсөн тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд нь энэ тухайгаа оршин суугаа орон нутгийн улсын бүртгэлийн байгууллага, сум,



хорооны нийгмийн ажилтанд заавал мэдэгдэнэ. Мэдэгдээгүйн улмаас илүү олгогдсон мөнгөн хуримтлалыг буруутай этгээдээс нөхөн төлүүлэх бөгөөд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.3.Нийгмийн халамжийн болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, банкны ажилтны гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлж, хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.4.Хүүхдийн мөнгөн хуримтлал, эсхүл мөнгөн хэлбэрээр олгосон хөрөнгийг барьцаалж зээл авах, олгох, банкны зээл суутгахыг хориглоно.

6.5.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага эцэг, эх, асран хамгаалагчийг эрэн хайх, сураггүй алга болсон талаарх лавлагааг цагдаагийн байгууллагаас авна.

---o0o---



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 7

Индекс: 200003